МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -08- 15
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

СЗХ
2022 .08. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Андеррайтер:

MANDAL CAPITAL

# ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

## ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгө оруулагч
танд зориулав

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЭХ 2022 08 10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-08-15 БҮРТГЭВ-03

## АГУУЛГА

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ ..... 5
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ..... 6
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ..... 7
ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 9
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ..... 10
НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН ..... 12
1.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ..... 13
1.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ..... 19
1.3 ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ ..... 21
ХОЁР. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ..... 22
2.1 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ..... 23
2.2 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 25
2.3 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ..... 30
ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 37
3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 38
3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 39
3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ..... 41
3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ ..... 42
3.5 ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ ..... 45
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ..... 47
4.1 ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ ..... 48
4.2 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ ..... 50
4.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ..... 52
4.4 ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ ..... 53
4.5 ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ ..... 54
4.6 ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ..... 60
4.7 ТАТАН БУУГДАХ, ХӨРӨНГИЙГ ДАХИН ҮНЭЛЭХ НӨХЦӨЛ ..... 61
4.8 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ..... 62
ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ..... 66
5.1 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ..... 67
5.2 ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ ЖУРМУУД ..... 69



УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЭХ
он сар өдөр
Б 2022 ТӨГ ТӨВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-08-15
БҮРТГЭВ-01

ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ..... 71
6.1 ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР ..... 72
6.2 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР ..... 73
6.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ..... 73
6.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ ..... 74
6.5 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ..... 74
ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ..... 77
7.1 АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ ..... 78
7.2 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ ..... 80
7.3 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 81
7.4 ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 82
НАЙМ. ХАВСРАЛТ ..... 85
8.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 86
8.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 88
8.3 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИЙН ДҮРЭМ ..... 92
8.4 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 99
8.5 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 101
8.6 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ 106
8.7 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 107
8.8 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 108
8.9 САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ..... 109
8.10 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ ..... 110
8.11 ХУУЛИЙН ФИРМИЙН ДҮГНЭЛТ ..... 118

## ЗУРАГ

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, хувиар ..... 13
Зураг 2. Экспортын голлох бүтээгдэхүүн, сая ам.доллар ..... 14
Зураг 3. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөгөөр ..... 15
Зураг 4. Инфляцын түвшин, жилийн ..... 16
Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, хувиар ..... 18
Зураг 6. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллараар ..... 18
Зураг 7. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр ..... 19
Зураг 8. Хөрөнгийн биржийн индексүүд ..... 20
Зураг 9. Хөрөнгийн зах зээлийн арилжааны дүн, тэрбум төгрөгөөр ..... 20
Зураг 10. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн салбаруудын байршил ..... 24
Зураг 11. Зээлдэгчийн тоо ..... 25
Зураг 12. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт ..... 27

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЭХ
2022 08 10
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03



Зураг 13. Хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр ... 31
Зураг 14. Зээлийн үлдэгдэл, чанараар ... 32
Зураг 15. Зээлийн бүтэц, хувиар ... 32
Зураг 16. Өөрийн хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр ... 33
Зураг 17. Өр төлбөрийн бүтэц, хувиар ... 33
Зураг 18. Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр ... 34
Зураг 19. Хүүгийн орлого, тэрбум төгрөгөөр ... 34
Зураг 20. Инфляц ба хадгаламжийн хүүний түвшин, хувиар ... 50
Зураг 21. Системийн нөлөө бүхий топ-5 банкны хадгаламжийн хүү, хувиар ... 51
Зураг 22. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны хүү, хувиар ... 52
Зураг 23. Үнэт цаасны арилжаанд оролцох заавар ... 73

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл ... 14
Хүснэгт 2. Инфляцын төсөөлөл ... 17
Хүснэгт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл ... 23
Хүснэгт 4. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн бүтээгдэхүүний мэдээлэл ... 24
Хүснэгт 5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц ... 25
Хүснэгт 6. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр ... 30
Хүснэгт 7. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн орлогын тайлан, сая төгрөгөөр ... 33
Хүснэгт 8. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд ... 34
Хүснэгт 9. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан байдал ... 36
Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл ... 38
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, сая төгрөгөөр ... 41
Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл ... 42
Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл ... 43
Хүснэгт 14. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал ... 43
Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл ... 44
Хүснэгт 16. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр ... 52
Хүснэгт 17. Төлбөрийн хуваарь ба аргачлал ... 53
Хүснэгт 18. Төлбөрийн график, сая төгрөгөөр ... 54
Хүснэгт 19. Багцын тойм ... 54
Хүснэгт 20. Хуулийн шаардлага хангасан байдал ... 55
Хүснэгт 21. Зээлийн багц, дүнгээр ... 57
Хүснэгт 22. Зээлийн багц, хугацаагаар ... 58
Хүснэгт 23. Зээлийн багц, улирлаар ... 58
Хүснэгт 24. Зээлийн багц, хүүний түвшнээр ... 59
Хүснэгт 25. Зээлийн багцын барьцаа, LTV харьцаа ... 59

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ [illegible]

Bers ABS active

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 08 сарын 03 өдөр

№ 22/212/33

Улаанбаатар хот

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.5 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.2 дахь заалт, Компанийн дүрмийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн "Бэрс Эй Би Эс актив ТЗК" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

1. "Бэрс Эй Би Эс актив ТЗК" ХХК нь 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгийн нийт дүнтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 100,000 (нэг зуун мянга) ширхэг хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж дээр нийтэд санал болгон гаргасугай.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг Хавсралт 1-р, Автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцын зээлийн дансны мэдээлэл, жагсаалтыг Хавсралт 2-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуурыг Хавсралт 3-р, Зээлийн хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн шалгуурын Хавсралт 4-р тус тус баталсугай.

3. Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх, үнэт цаасыг бүртгэсний дараа Багцын хөрөнгийн барьцааны болон Зээлийн төлбөр хүлээн авах дансны барьцааны гэрээг хөдлөх хөрөнгийн барьцааны цахим санд бүртгүүлэх зэргээр энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Үйлчилгээ үзүүлэгч (С.Отгонбат)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг "Бэрс Эй Би Эс актив ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

| | |
|---|---|
| ТУЗ-ИЙН ДАРГА | Б.БОЛОР-ЭРДЭНЭ |
| ТУЗ-ИЙН ГИШҮҮН | С.ОТГОНБАТ |
| ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Д.БААТАРЖАВ |

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ 2022.08.10 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2022-08-15 БҮРТГЭВ-03

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж нийтэд санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100,000 ширхэг үнэт цаасыг нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Үнэт цаас гаргагч Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК нь энэхүү 10,000,000,000 төгрөгийн үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК-аас зээлийн багц шилжүүлэн авахад ашиглах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд зарцуулна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн Зохицуулах Хороо хариуцахгүй болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хөндлөнгийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК болон Андеррайтер Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
он сар өдөр
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд үнэт цаасыг худалдаж буй үйл ажиллагаа |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгч | Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд буюу Бэрс Финанс ББСБ ХХК |
| Баталгаат үнэт цаас | Үнэт цаас гаргагчийн арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаас |
| Биржэсхүл МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| Зээлдэгч | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн холбогдох журамд заасан шалгуурыг хангаж зээл авсан хувь хүн, хуулийн этгээд |
| Зээлийн баримт бичгүүд | ББСБ-аас зээлдэгчид зээл олгосон автомашины зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, бусад баримт бичгүүд |
| Зээлийн гэрээ | Зээлдэгч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээ |
| Зээлийн дансны бүртгэл | Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээлэл |
| Зээлийн эргэн төлөлт | Зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх зээлийн үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү |
| Төлбөр цуглуулах данс | Зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг хүлээн авах зорилгоор банканд тусгайлан нээсэн тусгай зориулалтын компанийн данс |
| Үйлчилгээ үзүүлэгч | Үнэт цаас гаргагчтай байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд зээлийн эргэн төлөлттэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэх үйлчилгээг үзүүлж буй этгээд |
| Үнэт цаас гаргагч | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож буй тусгай зориулалтын компани буюу Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК |
| Үнэт цаас эзэмшигч | ТЗК-ийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авч, эзэмшиж буй этгээд |
| Үнэт цаасны төлбөр | Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр |
| ҮЦТХТ | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| ҮЦТ | Энэхүү үнэт цаасны танилцуулга |
| Хороо эсхүл СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 ☎ 6862349
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

| | |
|---|---|
| Хөрөнгийн багц эсхүл багц | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хооронд "Хөрөнгө худалдах, худалдаж авах" гэрээний 1 дүгээр зүйлд тодорхойлогдсон, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүд |
| Хөрөнгийн багцын эсхүл багцын эргэн төлөлт | Сар тутам Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийн данснаас Үнэт цаас гаргагчийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийн нийлбэр дүн |
| Хөрөнгийн жагсаалт | Үнэт цаасны танилцуулга, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах, худалдаж авах гэрээ"-нд хавсаргасан хөрөнгийн жагсаалт |
| Хөрөнгө | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3.1.1-д заасан үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх |
| Хөрөнгө итгэмжлэн удирдагч | Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | Хөрөнгөөр баталгаждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас |
| Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх тохиолдол | Зээлдэгч сар тутам зээлийн эргэн төлөлтийн хуваарь дахь төлөх дүнгээс илүү дүнгээр зээлийн үлдэгдлээс хэсэгчлэн, эсхүл бүрэн төлөх тохиолдол |
| Шаардлага хангахгүй хөрөнгө | Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах, худалдаж авах гэрээ", "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-д тодорхойлсон хөрөнгө |
| Шалгуур үзүүлэлт | Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/33 тоот тогтоолоор баталсан хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүд |

## ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмын дагуу Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100,000 ширхэг, нийт 10,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож байна.

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгч | Бэрс Финанс ББСБ ХХК |
| Үнэт цаасны төрөл | Автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Үнэт цаасны тоо ширхэг | 100,000 ширхэг |
| Үнэт цаасны нийт үнийн дүн | 10,000,000,000 төгрөг |
| Үнэт цаасны хугацаа | 24 сар |
| Үнэт цаасны хүү | 16.8 хувь (жилийн) |
| Үнэт цаасны хүүний төлөлт | Улирал тутам |
| Үнэт цаасны үндсэн төлбөрийн төлөлт | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш<br>-12 дахь сард үндсэн төлбөрийн 50%<br>-24 дахь сард буюу хугацааны эцэст үндсэн төлбөрийн 50% |
| Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр | Зээлийн багцын үндсэн төлбөр болон хүүний орлого |
| Үнэт цаасны хүүд ногдох татвар | Хүүний орлогын 5.0 хувь |
| Үнэт цаасны хадгалалт | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| Анхдагч зах зээлийн захиалга | Бирж төвтэй |
| Арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн бирж |
| Арилжааны хэлбэр | Нээлттэй зах зээлд |
| Зээлийн багцын дүн | 10,330,821,621 төгрөг |
| Зээлийн тоо | 1,188 |
| Зээлдэгчдийн тоо | 1,186 |
| Барьцаа | Автомашины фидуци бүхий зээлийн багц |
| Зээлийн чанар | 100 хувь хэвийн |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн санхүүжилт |

СЗХ
он сар өдөр
2022 08 19
БҮРТГЭВ
№ 01



15
БҮРТГЭВ-03

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ

БЭРС ФИНАНС
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

### БЭРС ФИНАНС ББСБ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот

info@bersfinance.mn

(976) 7712-2020

www.bersfinance.mn

## АНДЕРРАЙТЕР

MANDAL CAPITAL

### МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мэру Тауэр, 6 давхар, 602 тоот

info@mandal.capital

(976) 7575-9911

www.mandal.capital

## ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ

Onch & Company

### ОНЧ АУДИТ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян-Гүний гудамж, ICC цамхаг, 15 давхар

info@onch.mn

(976) 7012-0450

www.onch.mn

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

## ХУУЛИЙН ФИРМ

### ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС ХХН

MDSKhanLex

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
- info@mdsa.mn
- (976) 11 330048
- www.mdsa.mn

## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ

### ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС ХХК

UAF ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС

- Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-хороо, Соёлын төв өргөө 10 давхар 1005 тоот
- info@uaf.mn
- (976) 7012-2346
- www.uaf.mn

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
он сар өдөр
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

Андеррайтер:

MANDAL CAPITAL

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
он ... сар ... өдөр
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

2022-08 15
БҮРТГЭВ-03

# 1.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Бодит сектор

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр үйлчилгээ, үйлдвэрлэл, агаарын тээвэр, аялал жуулчлал зэрэг салбаруудын үйл ажиллагаа зогсонги байдалд шилжсэнтэй холбоотойгоор 2020 онд бодит эдийн засаг 4.8 хувиар агшсан бол 2021 оны байдлаар 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 он гарснаар Монгол Улсын эдийн засгийн гол түнш орон болох БНХАУ-д Тэг-ковидын бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр том хот, мужуудад хөл хорио тогтоосон нь үйлдвэрлэл, худалдааны эргэлтийг бууруулах хөшүүрэг болсон. Энэ нь уул уурхайн экспортоос ихээхэн хамааралтай Монгол Улсын өсөлтийг бууруулах үйл явдал болов. Түүнчлэн 2022 оны 02-р сард гарсан ОХУ-Украины дайны асуудлаар нийлүүлэлтийн тасалдал үүсэж, газрын тосны үнэ өссөн нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. 2022 оны 1-р улиралд бодит дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 5.2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан үзүүлэлт юм.

Зураг 1. Эдийн засгийн өсөлт, хувиар




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

БНХАУ-ын хил гаалийн хязгаарлалт нь экспортын гарцад тасалдал үүсгэсэн нь эдийн засгийн ихэнх салбарт сөргөөр нөлөөлсөн. Салбараар нь авч үзвэл уул уурхай 37.1 хувиар, боловсруулалт 10.2 хувиар, барилга 29.9 хувиар, тээвэр 33.7 хувиар тус тус агшсан нь бодит өсөлт буурахад голлон нөлөөлсөн бол хөдөө аж ахуй 11.3 хувиар, худалдаа 7.3 хувиар, мэдээлэл, холбоо 14.9 хувиар өссөн нь эдийн засгийн томоохон агшилтыг хязгаарлахад хувь нэмэр болсон байна.



БЭРС ЭН БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

| | 2022Т[1] |
|---|---|
| Дэлхийн Банк | 2.5% |
| Олон Улсын Валютын Сан | 2.0% |
| Азийн Хөгжлийн Банк | 2.3% |
| Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк | 3.5% |
| Монголбанк | 2.6% |
| **Дундаж** | **2.6%** |

Эх сурвалж: Олон Улс болон дотоодын эдийн засгийн институц

Хилийн асуудал нь 2022 оны 2-р хагас хүртэл, цаашлаад 2022 оныг дуустал хэвээр үргэлжлэхээр хүлээгдээд байгаа бол ОХУ-Украины дайныг хэдий хугацаанд үргэлжлэх эсэхийг талуудын хэлэлцээр шийдэх магадлалтай байна. Улмаар олон улсын байгууллагуудын таамаглалаар бодит ДНБ өсөлт дунджаар 2.6 хувьтай байхаар хүлээгдэж байна.

## Гадаад сектор

2022 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдаа 450 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнд экспортын хэмжээ 2.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны үеэс 12.1 хувиар өссөн нь нөлөөлсөн. Гэвч дайн гарснаас хойш Монгол Улсын ОХУ-аас авдаг гол импортын бүтээгдэхүүн болох түлш, шатахууны өртөг нэмэгдсэн нь импортыг 2.3 тэрбум ам.долларт хүргэж, улмаар гадаад худалдааны тэнцэл өмнөх оны үеэс 16.0 хувиар буурахад хүргэв. 2022 оны 02-р сараас хойш газрын тосны үнэ нэг баррель нь дунджаар 106.5 ам.долларт хүрч өссөн байна.

Зураг 2. Экспортын голлох бүтээгдэхүүн, сая ам.доллар




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт нь Монгол Улсын экспортын салбарын өсөлтөд эерэг нөлөөлсөн боловч хилийн хязгаарлалтаас шалтгаалж, түүхий эдийн гарц муу байна. Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнийн өсөлтөөс хангалттай ашиг хүртэж чадахгүй байгаа юм. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх жилээс 20.4

[1] Т-Төсөөллийг илэрхийлнэ.

хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний импорт 56.5 хувиар, машин, тоног төхөөрөмж 3.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

## Төсвийн сектор

2022 оны эхний 4 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 552 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан. Нэгдсэн төсвийн орлого 2021 оны 04-р сард 2020 оны үеэс 75.8 хувиар өсөж, 5.1 их наяд төгрөгт хүрээд байсан бол 2022 онд энэ үр дүн 10.8 хувиар буурч 4.6 их наяд төгрөгт хүрээд байна. Тус бууралтын гол шалтгаан нь орлогын албан татварын орлогын бууралт буюу ААНОАТ-ын бууралт байв.

Тайлант хугацаанд ААНОАТ-ын орлого 33.2 хувиар буурсан бол ХХОАТ 23.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 39.8 хувиар, НӨАТ-ын орлого 35.8 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн Газар 2022 онд төсвийн орлогыг бизнесийн орлогоос бус иргэдийн орлогоос бүрдүүлэх болжээ. Хэдийгээр дотоодод цар тахлын хөл хориог сулруулсан ч олон улсын эдийн засгийн орчин тааламжгүй байгаагаас бизнесүүд орлогоо алдаж байгаа тул төсвийн орлогыг хангалттай бүрдүүлж чадахгүй байна.

Зураг 3. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Монгол Улсын Засгийн газраас татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, урсгал шилжүүлэг, цалин хөлсний зардлыг нэмэгдүүлэх замаар дотоод эдийн засаг дахь эрэлтийг дэмжих зорилгоор мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Цар тахлын нөлөөгөөр 2020 онд Монгол Улсын нийт төсвийн алдагдал ДНБ-ний 9.6 хувьтай тэнцэж байсан бол 2021 онд 3.4 хувьтай тэнцэж байна.

2022 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс өрхүүдийн цахилгаан, усны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээ зогсоосноор урсгал шилжүүлгийн зардал буурах боломжтой. Түүнчлэн танах боломжтой хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудыг бууруулснаар 2022 онд төсвийн зардал буурах боломжтой хэдий ч их хэмжээгээр буурах хүлээлтгүй байгаа юм. 2023 онд Монгол Улсын Засгийн газрын гадаад өр төлөгдөж эхэлснээр төсвийн зардал үлэмж хэмжээгээр нэмэгдэхээр хүлээлт үүснэ.

Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахын тулд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Цаашид хил гаалийн хязгаарлалт, олон улсын геополитикийг тойрсон тодорхойгүй байдал буурахгүй төсвийн тэнцлийн алдагдал 2022 онд ДНБ-ий 5.0, 2023 онд 8.0-11.0 орчим хувьтай тэнцүү байхаар хүлээгдэж байна.

## Мөнгөний сектор

### Инфляц

2021 оны эхний 3 сард цар тахлын өвчлөлийн тохиолдол нэмэгдсэн нь улс орнуудад дотооддоо хөл хорио тогтоохоос өөр аргагүй байдалд хүргэснээр хилийн хязгаарлалт тогтоож, үйлдвэрлэлийн гарц огцом буурсан. Энэ нь улс орнуудад 2-3 сарын хоцрогдолтойгоор нийлүүлэлтийн гаралтайгаар нөлөөлсөн бөгөөд Монгол Улсад 2021 оны 06-р сараас эхлэн инфляцын түвшин огцом нэмэгдсэн.

Улмаар 2022 оны 05-р сард Монгол Улсын хэмжээнд инфляцын түвшин 15.1 хувьд хүрлээ. Тус өсөлтөд тээврийн зардал 25.6 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн ба хүнсний бүтээгдэхүүн 16.8 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 15.2 хувиар, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ 15.0 хувиар тус тус өссөн нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлжээ.

Зураг 4. Инфляцын түвшин, жилийн




Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын хэрэглээний сагсны 40 орчим хувийг импортын бараа бүтээгдэхүүн эзэлдэг. Импортын барааны үнийн өсөлт нэмэгдэхэд шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлт, бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хүндрэл, хил гаалийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын хэрэглээний үнэ нийлүүлэлтийн гаралтай өссөн. Хил гааль хаалттай байгаа нь БНХАУ болон ОХУ-ын агуулахад хадгалах зардлыг нэмэгдүүлж байгаа ба мөн газрын тосны үнэ өссөн нь тээврийн машин, галт тэрэгний түлш, шатахууны зардлыг нэмэгдүүлж байгаа нь импортын бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлээд байна.

Хүснэгт 2 Инфляцын төсөөлөл

| | 2022Т |
|---|---|
| Олон Улсын Валютын Сан | 15.5% |
| Азийн Хөгжлийн Банк | 12.4% |
| Монголбанк | 13.0% |
| **Дундаж** | **13.6%** |

Эх сурвалж: Олон Улс болон дотоодын эдийн засгийн институц

ОХУ-Украины дайн нь нийт импортын 30 орчим хувийг хойд хөршөөсөө импортолдог Монгол Улсын хувьд импортын гол бүтээгдэхүүн болох газрын тос, цахилгаан, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасрах, үнэ нэмэгдэх нөхцөлийг бий болгоод байна. Үүнээс хамаарч олон улсын болон дотоодын шинжээчдийн зүгээс инфляцын түвшинг 2022 онд оны эцэст дунджаар 13.6 хувьд хүрнэ гэж төсөөлж байна.

Цаашид цар тахлын нөхцөл байдал сайжрахгүй, хил гааль, тээвэрлэлтийн нөхцөл байдал хэвийн нөхцөл рүү шилжихгүй бол хэрэглээний үнийн өсөлт төсөөллөөс давж өндөр түвшинд хэвээр хадгалагдах эрсдэлтэй. Тээвэрлэлт, дэлхийн зах зээл дээрх бүтээгдэхүүний үнийн өсөлтөд Монголбанкны мөнгөний бодлогын зохицуулалтууд, арга хэрэгслүүд төдийлөн нөлөө үзүүлж чадахгүй төлөвтэй байна.

## Мөнгөний нийлүүлэлт, мөнгөний бодлого

2022 оны 03-р сарын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх оны үеэс 4.0 хувиар, өмнөх оны эцсээс 5.2 хувиар буурч, 26.4 их наяд төгрөгт хүрсэн. М2 мөнгөний жилийн өсөлтөд төгрөгийн харилцах 37.1 нэгж хувиар, валютын харилцах 22.0 нэгж хувиар өссөн нь нөлөөлсөн бол хадгаламжийн хүү буурсантай холбоотойгоор төгрөгийн хадгаламж 4.6 нэгж хувиар, валютын хадгаламж 3.7 нэгж хувиар буурсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлсэн.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо мөнгөний бодлогын хүүг 2020 онд 6 хувьд барьж байсан бол 2022 оны 02-р сарын байдлаар инфляцыг нам түвшинд байлгах, хязгаарлах зорилгоор бодлогын хүүг 3 нэгж хувиар нэмэгдүүлэн 9 хувьд хүргэснээр мөнгөний нийлүүлэлт буурч эхэлсэн. Энэ нь хадгаламжийн хүү нэмэгдэх суурь болж байгаа ба арилжааны банкуудын хадгаламжийн дундаж хүү 9.5 хувьд хүрсэн нь мөнгөний нийлүүлэлт харилцах данснаас хадгаламж руу шилжих хүлээлтийг бий болгоод байна.

Долларын ханшийн нийлүүлэлтийн гаралтай өсөлт бий болоод байгаагаас харилцах дансны долларжилт 37.2 хувьд, хадгаламж дахь долларжилт 24.1 хувьд хүрээд байгаа нь 2020 оны 12 сараас хойшхи хамгийн өндөр үзүүлэлт юм.

СЗХ
он сар өдөр 2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -08- 15
БҮРТГЭВ-03

Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, хувиар




Эх сурвалж: Монголбанк

2021 оны дунд үеэс иргэд, аж ахуй нэгжийг дэмжих, цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор (1) Монгол Улсын Засгийн Газар эдийн засгийн дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн (2) банкууд репо санхүүжилт авч иргэд, аж ахуй нэгжид бага хүүтэй зээл тогтмол олгож буй нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц болсон. Өөрөөр хэлбэл сүүлийн нэг жилийн хугацаанд төрөөс аж ахуй нэгжийг дэмжиж буй бодлогын арга хэмжээнүүдийн нөлөөгөөр төгрөгийн харилцах данс өмнөх оны үеэс 37.1 хувиар өссөн.

## Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2022 оны 1-р улиралд 954 сая ам.долларын алдагдалтай, урсгал данс 1,070 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 295 сая ам.долларын ашигтай байна.

Зураг 6. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллараар




Эх сурвалж: Монголбанк

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

Ковид-19 цар тахлыг хязгаарлах дэлхийн улсуудын бодлогоос шалтгаалан дэлхий даяар үйлчилгээний салбарын үйл ажиллагааны идэвх саарсан, гадаад үйлчилгээний эрэлт буурсан нь Монгол Улсын төлбөрийн тэнцэл дээрх үйлчилгээний алдагдал өсөхөд нөлөө үзүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын төлбөрийн тэнцэл дээрх үйлчилгээний данс 450 сая ам.долларын алдагдалд хүрсэн. Энэ нь дэлхийн ихэнх улсууд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор аяллын хязгаарлалт тогтоож буй нь аялал жуулчлалын салбарт, мөн тээврийн сүлжээний тасалдал нь тээврийн салбарт нөлөөлж, алдагдлыг нь нэмэгдүүлэх болсон.

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулагч компаниудын үйл ажиллагаа сэргэснээр ногдол ашгийн шилжүүлэг, гадаад ажилтнуудын цалингийн шилжүүлэг нэмэгдэж, анхдагч орлогын алдагдал 507 сая ам.долларт хүрсэн байна. Харин хоёрдогч орлого буюу урсгал шилжүүлгийн орох урсгал 4.8 хувиар буурч, 150 сая ам.долларт хүрсэн нь цар тахлыг даван туулахад чиглэсэн гадаадын буцалтгүй тусламж татарснаас үүдэлтэй байна.

## 1.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

### Дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны байдлаар 5.98 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буюу 97.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Тодруулбал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 онд ДНБ-ий 8.1 хувьтай тэнцүү байсан бол 2021 оны байдлаар 5.8 нэгж хувиар нэмэгдэж 13.9 хувьд хүрсэн.

Зураг 7. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### Хөрөнгийн зах зээлийн индекс

2021 оны байдлаар Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр арилжаалагддаг хөрвөх чадвар болон зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч 20 хувьцааны хөдөлгөөнийг харуулдаг ТОП-20 индекс 130 хувь, хувьцааны бүртгэлийн I ангиллын хувьцааг илэрхийлдэг MSE A индекс 70 хувь, II ангиллын хувьцааг илэрхийлдэг MSE-B индекс 61 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн.

Зураг 8. Хөрөнгийн биржийн индексүүд




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## Хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх

2021 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх 1.4 их наяд төгрөгт хүрсэн нь 2018 оноос 5.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд арилжааны дүн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас улбаалан 65.3 тэрбум төгрөг болж буурсан боловч 2021 онд бодлогын эерэг өөрчлөлтийн улмаас арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 22 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

Зураг 9. Хөрөнгийн зах зээлийн арилжааны дүн, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2021 оны нийт арилжааны 74.0 хувийг компанийн нээлттэй бонд буюу ЭТТ бонд, Монпэй бонд, Лэнд бонд Инвескор бондууд бүрдүүлж байна. Тус хугацаанд Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС, Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК, Богд Банк ХК анхдагч зах зээлд анх удаа болон нэмэлт хувьцаа гаргаж нийтэд санал болгосон.

СЗХ
2022 . 08. 10 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 1.3 ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ

Бодлогын хүүний өөрчлөлт, өндөр инфляцын орчин, эдийн засгийн удаашралтай зах зээлийн тогтворгүй энэ үед тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний эрэлт хөрөнгө оруулагчдын дунд өндөр байна. Тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнээс эрсдэлийн түвшинг хамгийн бага түвшинд байхаар бүтэцлэгдсэн бүтээгдэхүүн нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ) юм. ХБҮЦ нь ирээдүйд мөнгөн урсгал бий болгох хөрөнгийг багцалж үнэт цаасжуулдаг.

### Тогтмол өгөөж

ХБҮЦ нь хадгаламжийн бүтээгдэхүүн, Засгийн Газрын болон компанийн бондтой өгөөжийн түвшинд ижил шинж чанартай буюу тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл, ХБҮЦ-д хөрөнгө оруулагч нь үнэт цаасыг эзэмшсэнээр тогтмол хүүний орлоготой болно.

### Хөрвөх чадвар

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийн хуваариас шалтгаалан Үнэт цаас эзэмшигч нь үндсэн төлбөрийн тодорхой мөнгөн урсгалыг хугацаанаас өмнө хүлээн авах боломжтой. Тодруулбал, Бэрс хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны хувьд Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойшхи 12 дахь сард үндсэн төлбөрийн 50 хувийг, 24 дахь сард буюу хугацааны эцэст үлдэгдэл 50 хувийг хүлээн авах боломжтой байгаа нь үнэт цаасны хөрвөх чадварыг хангаж, дахин хөрөнгө оруулалтын боломжийг бүрдүүлж байна.

### Эрсдэлийн саармагжуулалт

ХБҮЦ-ны баталгаа болж буй хөрөнгө нь тогтмол мөнгөн урсгал бүхий олон тооны багц хөрөнгөөс бүрддэг. Энэхүү багцад тусгай зориулалтын компани (ТЗК)-н Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-с баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу сонгогдсон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгүүд багтсан. Тус шалгуур үзүүлэлтийг хөндлөнгийн зээлийн шинжилгээ гаргагч болон хуулийн дүгнэлт гаргагчаар баталгаажуулдаг. Түүнчлэн Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хэвийн зээлийн хөрөнгийг тусгай зориулалтын компани руу шилжүүлснээр зээлийн эрсдэлийг бууруулдаг.

### Хяналтын тогтолцоо

Үнэт цаас гаргагч ТЗК-ийн хөрөнгийг СЗХ-с тусгай зөвшөөрөлтэй хөрөнгө итгэмжлэн удирдагч компани удирдаж, данс захиран зарцуулах эрхийг хүлээн авдаг. Энэ нь ТЗК-ийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, үнэт цаасны төлөлт зориулт бусаар ашиглагдахаас сэргийлдгээрээ онцлогтой. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах үйл ажиллагаанд хөндлөнгийн хуулийн болон санхүүгийн дүн шинжилгээ хийсэн байгууллага, андеррайтер компаниуд оролцож, эрх бүхий зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр нийтэд санал болгодог. Түүнчлэн Үнэт цаас гаргагч ТЗК-ийн хөрөнгийг хөндлөнгийн хөрөнгө итгэмжлэн удирдагч компани удирдсанаар үнэт цаасны хяналтын тогтолцоог хангаж ажилладгаараа онцлогтой.

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЭХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 08 15
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ

## АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

Андеррайтер:

MANDAL CAPITAL

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

## 2.1 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

Хүснэгт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Бэрс Финанс ББСБ ХХК |
| Хувьцаа эзэмшигч | Бэрс Капитал ХХК /100 хувь/ |
| СЗХ-ны тусгай зөвшөөрлийн дугаар | ТЗ 101/622 |
| Үйл ажиллагааны чиглэл | Зээл, факторинг, итгэлцэл, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2017.05.18 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9015005096 |
| Регистрийн дугаар | 6186858 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот |
| Утас | +976 7712-2020 |
| Цахим шуудан | info@bersfinance.mn |
| Цахим хаяг | www.bersfinance.mn |

Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үүсгэн байгуулагч Бэрс Финанс ББСБ ХХК нь 2017 онд Хөвсгөл, Дархан, Орхон, Баянхонгор, Өмнөговь, Өвөрхангай, Дорноговь, Увс, Ховд, Сүхбаатар, Сэлэнгэ зэрэг аймгуудад нийт 12 салбартайгаар үйл ажиллагаа эхлүүлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос 101/622 тоот тусгай зөвшөөрлийг хүлээн авч орон нутгийн зах зээлд үйл ажиллагааг эхэлсэн.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК нь Улаанбаатар хотод 2 салбар, орон нутагт 19 салбартайгаар банк бус санхүүгийн чиглэлийн зээл, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхэлж байна.

СЗХ БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ STOCK EXCHANGE 2022-08-15 БҮРТГЭВ-03

Зураг 10. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн салбаруудын байршил



Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн мэдээлэл

Бэрс Финанс ББСБ ХХК нь нийт 5 төрлийн автомашины зээлийн бүтээгдэхүүн, 5 төрлийн үл хөдлөх барьцаалсан зээл буюу нийт 10 төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад санал болгодог.

Автомашины фидуци бүхий зээлийн хувьд зээлийн хугацаа 48 сар хүртэл, дээд хэмжээ 30 сая төгрөг хүртэл зээл олгодог бөгөөд автомашины фидуци бүхий, эсхүл автомашин барьцаалсан болон автомашин худалдан авах бүх төрлийн зээлийг харилцагчдад санал болгодог. Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн хувьд барьцаа хөрөнгийн үнэлгээнээс хамааран зээлийн хэмжээ тогтож, 36 сар хүртэлх хугацаатай олгогддог.

Хүснэгт 4. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн бүтээгдэхүүний мэдээлэл

| Төрөл | Зээлийн лимит | Зээлийн хүү, сарын | Зээлийн хугацаа |
|---|---|---|---|
| Автомашин худалдан авалт - Гаалийн бичигтэй | 30 сая төгрөг | 2.9%-3.2% | 48 сар хүртэл |
| Автомашин худалдан авалт - Улсын дугаартай | | 2.9%-3.8% | |
| Автомашин худалдан авалт - Эко Кар Центр | | 2.8% | |
| Автомашин барьцаалсан зээл - Зогсоол | | 2.7%-3.0% | |
| Автомашин барьцаалсан зээл - Унах | | 3.5%-4.9% | |
| Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл- Орон сууц | Орон сууцны жишиг үнийн 40 хүртэл хувь | 3.9% | 36 сар хүртэл |
| Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл- Хашаа байшин | Барьцаа хөрөнгийн үнэлгээ 30 хүртэл хувь | | |
| Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл- Өмчлөх эрхтэй газар | | | |
| Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл- Обьект | | | |
| Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл- Гараж | Зах зээлийн үнийн дүнгийн 20 хүртэл хувь | | 24 сар хүртэл |

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн мэдээлэл

УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК нь нийт 8,080 харилцагчдад зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байна. Энэ нь 2019 оны эцэстэй харьцуулахад 1.2 дахин өссөн үзүүлэлт буюу компанийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжин тэлж байгааг харуулж байна.

Зураг 11. Зээлдэгчийн тоо




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн мэдээлэл

## 2.2 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Хувьцаа эзэмшигчид

Монгол Улсын хуулийн этгээд болох Бэрс Капитал ХХК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК-ийн 100 хувийг (1,000 ширхэг хувьцаа) дангаар эзэмшдэг. Бэрс Капитал ХХК-ийн 100 хувийг ноён С.Отгонбат эзэмшдэг.

Хүснэгт 5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн мэдээлэл

СЗХ 2022.08.10 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-08-15 БҮРТГЭВ-03

## Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн ТУЗ нь 3 хараат гишүүн, 2 хараат бус гишүүнтэй буюу нийт 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

---

**Ядамсүрэн овогтой Оюумаа**
**ТУЗ-ийн дарга**

Боловсрол:

2003-2008 он: Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль – Англи хэлний орчуулагч

Ажлын туршлага:

2008-2009 он: ХААН Банк – Орлогч захирлын туслах
2009-2010 он: Хадгаламж Банк – Гадаад харилцааны менежер
2010-2018 он: Капитал Банк – Гадаад төлбөр тооцооны мэргэжилтэн
2018 оноос одоог хүртэл: Эко Кар Центр ХХК – Худалдааны зөвлөх

---

**Самдан овогтой Дамдинбазар**
**ТУЗ-ийн гишүүн**

Боловсрол:

1999-2003 он: Сити Дээд Сургууль – Үйлдвэрлэлийн менежмент, бакалавр

Ажлын туршлага:

2003-2007 он: Улаанбаатар төмөр зам ХНН – Ахлах менежер
2010-2012 он: Бичил Глобус ХХК – Эрсдэл хариуцсан захирал
2012-2017 он: Бичил Глобус ХХК – Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга
2017 оноос одоог хүртэл: Хувиараа бизнес эрхлэгч

---

**Жадамба овогтой Мөнхсоёмбо**
**ТУЗ-ийн гишүүн**

Боловсрол:

1999-2003 он: Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнес удирдлага, бакалавр

Ажлын туршлага:

2003-2005 он: Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнесийн зөвлөх төвийн зөвлөх
2009-2011 он: Бичил Глобус ХХК – Салбарын эрхлэгч
2011-2016 он: Хос Шивээт ХХК – Гүйцэтгэх захирал
2016 оноос одоог хүртэл: Хувиараа бизнес эрхлэгч

---

**Батсуурь овогтой Батсолонго**
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

Боловсрол:

2002-2007 он: ШУТИС Холбоо мэдээллийн технологийн сургууль – Мэдээллийн сүлжээний инженерийн бакалавр
2007-2009 он: ШУТИС Холбоо мэдээллийн технологийн сургууль – Мэдээллийн сүлжээний инженерийн магистр
2016 оноос одоог хүртэл: МУБИС – Боловсролын удирдлагын Докторант

Ажлын туршлага:

2006-2008 он: Улуснэт ХХК – Инженер
2008-2009 он: Засгийн Газрын хэрэг эрхлэх газар – Шинжээч



УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS ҮЦК

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2009-2010 он: ГХБАБГазрын "Үндэсний газрын мэдээллийн систем"-ийн төсөл – Инженер
2011-2012 он: ЗГХА Төмөр замын газар – Бүртгэлийн техникч
2012-2013 он: МТШХХГазар – Мэргэжилтэн
2013 оноос одоог хүртэл: МУБИС – Менежер, албаны дарга

2022-08-15
БҮРТГЭВ-03

---

**Дашдаваа овогтой Гантулга**

**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол:**

2008-2012 он: Дархан Дээд Сургууль – Аялал жуулчлал, гадаад хэлний удирдлагын ухааны бакалавр

**Ажлын туршлага:**

Одоог хүртэл: Гоэн девелопмент ХХК – Гүйцэтгэх захирал

---

## Бүтэц, зохион байгуулалт

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн олон талт харилцаа, түүнд оролцогч талуудын эрх зүйн тэнцвэртэй байдлыг хангасан зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Бэрс Финанс ББСБ ХХК нь төвлөрсөн төв оффистой, түүгээр дамжуулан салбаруудыг мэргэжлийн чиг удирдлагаар хангаж ажилладаг. Төв оффис нь нийт 6 газар, хэлтсээс бүрддэг ба үүнд Захиргаа удирдлагын газар, Санхүү бүртгэлийн газар, Зээлийн газар, Дотоод хяналтын газар, Бизнес хөгжлийн газар, Мэдээлэл технологийн хэлтсийг хамарсан нийт 20 гаруй ажилтантай. Бусад салбар нэгжийн хувьд Улаанбаатар хотын салбарт 4 ажилтан, орон нутгийн салбар тус бүрт 3-4 ажилтан буюу нийт 64 ажиллагсадтай байна.

Зураг 12. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн мэдээлэл

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS ҮЦК

## Гүйцэтгэх удирдлага

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх удирдлагын баг нь Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк, Төрийн банк зэрэг системийн нөлөө бүхий арилжааны банкуудад өмнө ажиллаж байсан туршлагатай баг хамт олноос бүрдсэн.



С.Отгонбат

Гүйцэтгэх захирал

**Боловсрол:**

2006-2010 он: Алтай коллеж – Компьютерийн техникийн инженер, бакалавр

2011-2013 он: Монгол Улсын Их Сургууль – Олон Улсын эдийн засгийн харилцаа, магистр

**Ажлын туршлага:**

2006-2007 он: Оргил Хотхон ХХК – Гүйцэтгэх захирал

2008-2009 он: Номин Холдинг ХХК – Ахлах менежер

2017 оноос одоог хүртэл: Бичил Глобус ХХК, Бэрс Финанс ББСБ ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал



Б.Баярчимэг

Дэд захирал

**Боловсрол:**

1999-2003 он: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль – Банк, санхүү, бакалавр

2019-2020 он: Хөдөө Аж Ахуйн Их Сургууль – Бизнес удирдлага, магистр

**Ажлын туршлага:**

2003-2017 он: Төрийн Банк – Хяналт шалгалтын газрын захирал

2018-2019 он: Голомт Банк – Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал

2019 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК – Дэд захирал



Г.Юмсүрэн

Дотоод хяналтын газрын захирал

**Боловсрол:**

2005-2010 он: Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль – Бизнесийн удирдлага, бакалавр

2018-2020 он: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль – Бизнесийн удирдлага, магистр

**Ажлын туршлага:**

2011-2017 он: Бичил Глобус Групп ХХК – Ахлах менежер, Салбарын захирал, Хяналт эрсдэл хариуцсан захирал

2017-2019 он: Бичил Глобус ХХК – Зээлийн хэлтсийн захирал

2019 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК – Дотоод хяналтын газрын захирал



Н.Гантулга

Зээлийн газрын захирал

Боловсрол:

2001-2005 он: ШУТИС – Математик загварчлал, бакалавр

2011-2012 он: Газарчин их сургууль – Бизнес удирдлага, магистр

Ажлын туршлага:

2013-2014 он: Аварга Соёо ХХК – Оффис менежер

2015 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК – Салбарын эрхлэгч, Салбарын удирдлагын мэргэжилтэн, Зээлийн газрын захирал

---



Я.Адъяахүү

Санхүүгийн газрын захирал

Боловсрол:

1987-1991 он: МУИС Эдийн засгийн сургууль – Банкны эдийн засагч, бакалавр

1997-1998 он: Сайтама Их Сургууль – Төрийн удирдлага, магистр

Ажлын туршлага:

1992-1997 он: Зах зээл судлалын хүрээлэн – Судлаач

1998-2009 он: Худалдаа хөгжлийн банк – Эдийн засагч, Эрсдэлийн шинжээч, ДХА, Газрын захирал

2009-2015 он: Хас Банк – Хэлтсийн захирал, газрын захирал

2015-2017 он: Глашиер Ассет ХОМК – Гүйцэтгэх захирал

2018-2020 он: Нэткапитал ББСБ – Эрсдэлийн захирал, Дэд захирал

2020 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК – Санхүүгийн газрын захирал

---



Б.Даваабат

Бизнес хөгжлийн газрын захирал

Боловсрол:

2006-2008 он: Соёлын коллеж – Компьютерийн оператор

2008-2011 он: СУИС – Соёлын арга зүйч

Ажлын туршлага:

2011-2012 он: Хийморь Принтинг ХХК – Ахлах дизайнер

2012-2016 он: Креатив Пролайн ХХК – Бренд менежер, креатив директор

2016-2021 он: Бичил Глобус ХХК – Маркетингийн менежер

2021 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК – Маркетингийн хэлтсийн захирал, Бизнес хөгжлийн газрын захирал

СЭХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



У.Ундармаа

Хүний нөөцийн менежер

Боловсрол:

2001-2005 он: Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль – Сэтгүүлч, бакалавр

Ажлын туршлага:

2007-2018 он: Скайтел ХХК – Харилцагч хариуцсан менежер

2018-2021 он: Голомт Банк – Хүний нөөцийн менежер

2021 оноос одоог хүртэл: Бэрс Финанс ББСБ ХХК – Хүний нөөцийн менежер

## 2.3 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

### Санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 6. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр

| Үзүүлэлтүүд | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 I |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 727 | 1,083 | 588 | 2,803 | 3,035 |
| Зээл (Цэвэр) | 10,374 | 17,257 | 17,500 | 29,566 | 34,827 |
| *Нийт зээл* | *10,552* | *17,402* | *17,995* | *29,928* | *35,159* |
| *Зээлийн эрсдэлийн сан* | *(179)* | *(145)* | *(495)* | *(362)* | *(331)* |
| Хуримтлагдсан хүүний авлага | - | 391 | 471 | 588 | 705 |
| Бусад хөрөнгө | 1,909 | 365 | 658 | 8,715 | 14,673 |
| **Эргэлтийн хөрөнгө** | **13,010** | **19,095** | **19,217** | **41,672** | **53,240** |
| Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (Цэвэр) | 483 | 471 | 485 | 488 | 544 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **483** | **471** | **485** | **488** | **544** |
| **Нийт хөрөнгө** | **13,494** | **19,566** | **19,702** | **42,160** | **53,784** |
| Өрийн бичгийн өглөг | - | 1,360 | - | 4,200 | 10,000 |
| Итгэлцлийн өглөг | 465 | - | 71 | 4,007 | 6,195 |
| Банк, санхүүгийн байгууллага, бусад эх үүсвэрийн өглөг | 6,581 | 6,365 | 1,746 | 10,692 | 14,324 |
| Хуримтлагдсан хүүний өглөг | - | 2,543 | 772 | 721 | 1,014 |
| Бусад өр төлбөр | - | 176 | 404 | 682 | 686 |
| **Нийт өр төлбөр** | **7,046** | **10,444** | **2,992** | **20,302** | **32,219** |
| Хувьцаат капитал | 3,000 | 3,000 | 6,090 | 6,090 | 6,090 |
| Хуримтлагдсан ашиг | 3,448 | 6,122 | 10,620 | 15,768 | 15,476 |
| **Нийт эздийн өмч** | **6,448** | **9,122** | **16,710** | **21,858** | **21,566** |
| **Нийт өр төлбөр, эздийн өмч** | **13,494** | **19,566** | **19,702** | **42,160** | **53,784** |

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн 2018-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2022 оны 1-р улирлын татварын тайлан

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

## Хөрөнгө (актив)

2021 онд Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт хөрөнгө 42.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 2.1 дахин, 2022 оны 1 дүгээр улиралд 2021 оны эцэстэй харьцуулахад 28 хувиар өссөн байна. 2022 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр ББСБ салбарын нийт хөрөнгө 3.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Үүнээс 1.8 хувийг Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт хөрөнгө бүрдүүлж байна. Түүнчлэн Бэрс Финанс ББСБ ХХК нь цэвэр зээлийн хэмжээгээр 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ББСБ салбарын 1.6 хувийг эзэлж байна.

Зураг 13. Хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт хөрөнгийн 65 хувийг цэвэр зээл, 6 хувийг мөнгөн хөрөнгө, 30 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна. Бусад хөрөнгийн 11.7 тэрбум төгрөг нь Бэрс Финанс ББСБ ХХК-ийн холбоотой компани болох Бичил Глобус Финанс ББСБ ХХК-с авах гэрээт авлагын дүн бол 2.7 тэрбум төгрөг нь Бичил Глобус Финанс ББСБ ХХК-д байршуулсан итгэлцлийн дүн байна.

## Зээлийн багц

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК-ийн зээлийн багцын 75 хувийг автомашины зээл, 25 хувийг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл бүрдүүлж байна. Үүнд топ-40 зээлдэгчийн нийт зээлийн өөрийн хөрөнгөд эзлэх хувь 6.3 хувь, зээлийн дундаж үлдэгдэл 33 сая төгрөг байгаа нь зээлийн төвлөрөл бага байгааг илтгэж байна.

СЗХ
он сар өдөр
2022 ОНЫ ... В
№ 01



Зураг 15. Зээлийн бүтэц, хувиар




Зураг 14. Зээлийн үлдэгдэл, чанараар




**Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол**

2020 онд Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт зээлийн хэмжээ 18.0 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байсан бол 2021 онд 66 хувиар өсөж, 29.9 тэрбум төгрөгт хүрсэн. 2021 оны байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК-ийн цэвэр зээлийн хэмжээ 29.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 69 хувиар өссөн бол 2022 оны 1 дүгээр улиралд 34.8 тэрбум төгрөгт хүрч 2021 оны эцэстэй харьцуулахад 18 хувиар өссөн байна.

2021 оны байдлаар нийт зээлд эзлэх чанаргүй зээл 1.4 хувь, хугацаа хэтэрсэн зээл 2.8 хувь байна. Энэ нь 2021 оны ББСБ салбарын чанаргүй зээлийн дундаж түвшин болох 7.0 хувьтай харьцуулахад 5.6 нэгж хувиар бага буюу Бэрс Финанс ББСБ ХХК-ийн зээлийн багцын чанар сайн байгааг илэрхийлж байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт зээл 35.2 тэрбум төгрөгт хүрч 2021 оны эцэстэй харьцуулахад 17 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд чанаргүй зээл 1.0 хувь, хугацаа хэтэрсэн зээл 3.7 хувийг эзэлж байна.

## Эх үүсвэр (пассив)

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК нь нийт хөрөнгийн 60 хувийг өр төлбөрөөр, 40 хувийг эздийн өмчөөр санхүүжүүлж байна.

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт өр төлбөр 2022 оны 1 дүгээр улиралд 32.2 тэрбум төгрөгт хүрсэн. 2021 онтой харьцуулахад өрийн бичгийн санхүүжилт татсанаар эх үүсвэрийн төрөлжилт нэмэгдэж, итгэлцэл, бусад санхүүгийн байгууллагын эх үүсвэр болон өрийн бичгийн өглөг зэргээс өр төлбөр бүрдэж байна.

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн өөрийн хөрөнгийн 28 хувийг хувьцаат капитал, 72 хувийг хуримтлагдсан ашиг эзэлж байна. Бэрс Финанс ББСБ ХХК нь 2020 онд хувьцаат капиталын хэмжээг 3.0 тэрбум төгрөгөөс 6.1 тэрбум төгрөг болгож 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн.



УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

Зураг 17. Өр төлбөрийн бүтэц, хувиар




Зураг 16. Өөрийн хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол

## Орлогын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 7. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн орлогын тайлан, сая төгрөгөөр

| Үзүүлэлтүүд | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 I |
|---|---|---|---|---|---|
| **Хүүний орлого** | **5,348** | **7,578** | **8,604** | **9,870** | **3,584** |
| Зээлийн хүүний орлого | 5,348 | 7,292 | 8,604 | 9,852 | 3,584 |
| Бусад хүүний орлого | - | 286 | - | 18 | - |
| **Хүүний зардал** | **(6)** | **(2,544)** | **(1,088)** | **(933)** | **(1,030)** |
| Банк, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | (6) | (2,509) | (760) | (716) | (705) |
| Өрийн бичгийн хүүний зардал | - | (35) | (328) | (217) | (325) |
| **Цэвэр хүүний орлого** | **5,342** | **5,034** | **7,516** | **8,937** | **2,555** |
| Хүүний бус орлого | 5 | 54 | 15 | 68 | 25 |
| *Санхүүгийн үйлчилгээний орлого* | *5* | *54* | *15* | *68* | *25* |
| Хүүний бус зардал | (1,154) | (2,000) | (2,214) | (3,131) | (1,057) |
| *Боловсон хүчний холбогдолтой зардал* | *(808)* | *(1,476)* | *(1,604)* | *(1,957)* | *(719)* |
| *Бусад зардал* | *(346)* | *(524)* | *(610)* | *(1,174)* | *(339)* |
| Цэвэр хүүний бус орлого/зардал | (1,149) | (1,946) | (2,199) | (3,063) | (1,032) |
| **Эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг** | **4,193** | **3,088** | **5,318** | **5,874** | **1,522** |
| Болзошгүй эрсдэлийн зардал | (209) | (106) | (402) | (138) | (67) |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | **3,984** | **2,982** | **4,916** | **5,736** | **1,455** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | - | 5 | 93 | 4 | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | (3) | (14) | (10) | (18) | (2) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг | 3,981 | 2,972 | 4,998 | 5,722 | 1,453 |
| Орлогын албан татварын зардал | (1) | (298) | (500) | (574) | (146) |
| **Цэвэр ашиг /алдагдал** | **3,980** | **2,674** | **4,498** | **5,148** | **1,308** |

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн 2018-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, 2022 оны 1-р улирлын татварын тайлан

дараах цэвэр ашиг 5.1 тэрбум төгрөгт хүрсэн. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар цэвэр хүүгийн орлого 2.5 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг 1.3 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна.

Зураг 19. Хүүгийн орлого, тэрбум төгрөгөөр




Зураг 18. Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол

Цэвэр ашгийн маржин 2021 оны байдлаар 52 хувь, 2022 оны 1 дүгээр улиралд 36 хувь байна. Мөн цэвэр хүүгийн орлогын маржин 2021 оны эцсээр 91 хувийн үзүүлэлттэй байсан бол 2022 оны 1 дүгээр улиралд 71 хувьтай гарсан.

Цэвэр хүүний орлогын маржин болон цэвэр ашгийн маржин 2022 оны 1 дүгээр улиралд буурсан шалтгаан нь зээлийн санхүүжилт буюу банк, бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлүүд болон өрийн бичгийн санхүүжилтийн дүн 2022 оны 1 дүгээр улиралд 30.5 тэрбум төгрөг болж 2021 оны эцэстэй харьцуулахад 11.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр өрийн санхүүжилтийн өртөг өссөнтэй холбоотой байна.

## Санхүүгийн харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

Хүснэгт 8. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

| | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 I[2] |
|---|---|---|---|---|---|
| **Ашигт ажиллагаа** | | | | | |
| Цэвэр хүүний орлогын маржин | 100% | 66% | 87% | 91% | 71% |
| Цэвэр ашгийн маржин | 74% | 35% | 52% | 52% | 36% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 29% | 14% | 23% | 12% | 10% |
| Эздийн өмчийн өгөөж | 62% | 29% | 27% | 24% | 24% |
| Цэвэр зээл/Нийт хөрөнгө | 77% | 88% | 89% | 70% | 65% |
| **Санхүүгийн хөшүүрэг** | | | | | |
| Өр төлбөр/ Эздийн өмчийн харьцаа | 109% | 114% | 18% | 93% | 149% |
| Өр төлбөр/ Нийт хөрөнгийн харьцаа | 52% | 53% | 15% | 48% | 60% |

[2] 2022 оны эздийн өмчийн өгөөж, нийт хөрөнгийн өгөөжийн тооцоололд ашиглагдсан орлогын тайлангийн үзүүлэлтийг 2022 оны 1 дүгээр улирлын үзүүлэлтийг хадгална гэж тооцон жил рүү шилжүүлсэн. /2022 оны 1 дүгээр улирлын орлогын тайлангийн үзүүлэлт x 4/.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Хөрвөх чадвар** | | | | | |
| Эргэлтийн харьцаа | 28.0 | 3.3 | 15.4 | 2.1 | 1.7 |
| Эрсдэлийн сан байгуулалтын харьцаа | | 119% | 126% | 112% | 104% |

Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

### Ашигт ажиллагаа

Хөрөнгийн өгөөж болон Эздийн өмчийн өгөөжийн харьцаа нь компани хөрөнгө болон эздийн өмч ашиглан хэдий хэмжээний ашиг бий болгож буйг илэрхийлэх ашигт ажиллагааны үзүүлэлт юм. 2021 оны байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт хөрөнгийн өгөөж 12 хувь, эздийн өмчийн өгөөж 24 хувь байна.

Цэвэр хүүний маржин нь санхүүгийн байгууллагад тооцдог өндөр ач холбогдолтой үзүүлэлт бөгөөд тухайн компанийн зээл, факторинг, хөрөнгө оруулалт гэх мэт хүүний түвшний өөрчлөлттэй өндөр хамааралтай эргэлтийн хөрөнгөөрөө хэдий хэмжээний цэвэр хүүний орлого бүрдүүлж байгааг илэрхийлдэг. Тус үзүүлэлт нь Бэрс Финанс ББСБ ХХК-ийн хувьд 91 хувь байгаа нь компанийн санхүүжилт болон зээлийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг харуулж байна.

### Хөрвөх чадвар

Эргэлтийн харьцаа нь компани богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөөр барагдуулах боломжтой эсэхийг харуулдаг хөрвөх чадварын үзүүлэлт юм. Бэрс Финанс ББСБ ХХК-ийн эргэлтийн харьцаа 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.7 байгаа нь компани нь богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөр барагдуулах чадвартай байгааг илэрхийлж байна.

Эрсдэлийн сан байгуулалтын харьцаагаар тухайн компани байгуулсан эрсдэлийн сангаараа чанаргүй зээлийн хэдэн хувийг хаах чадвартай байгааг харуулдаг. Бэрс Финанс ББСБ ХХК нь 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар чанаргүй зээлийн 104 хувийн түвшинд эрсдэлийн сан байгуулсан нь зээлийн чанаргүйдлийн улмаас хөрвөх чадвар алдагдах эрсдэлийг бууруулж байна.

### Санхүүгийн хөшүүрэг

Өр төлбөр, эздийн өмчийн харьцаагаар тухайн компани эздийн өмчийн дүнгээс хэд дахин өндөр дүнгээр өр төлбөрийн санхүүжилт татсан байгааг илэрхийлдэг. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК-ийн нийт өр төлбөр нь эздийн өмчөөс 1.5 дахин өндөр байна.

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шинжилгээ

СЗХ-оос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу ББСБ нь 18 шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах шаардлагатай байдаг.

Тус зохистой харьцааны үзүүлэлтийг Бэрс Финанс ББСБ ХХК нь үйл ажиллагаа эхэлснээс хойш тогтмол хангаж ажиллаж байна. Тодруулбал, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Бэрс Финанс ББСБ ХХК нь хангалттай өөрийн хөрөнгөтэй, төлбөр гүйцэтгэх чадвар сайн, зээлийн багцын төвлөрөл бага, гадаад валютын эрсдэл бага, гадны эх үүсвэр ашиглаагүй буюу зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна.

СЗХ
2022.08сар10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 9. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан байдал

| Д/д | Зохистой үзүүлэлтүүд | Байвал зохих | Тайлангаар | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|
| | **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт** | | | |
| 1 | Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 39.4% | Хангасан |
| 2 | Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 39.4% | Хангасан |
| 3 | Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 40.1% | Хангасан |
| | **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа** | | | |
| 4 | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 9.4% | Хангасан |
| | **Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт** | | | |
| 5 | Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,-дутуу ) | 331,502 | 331,502 | Хангасан |
| 6 | Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 0.3% | Хангасан |
| 7 | ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 8 | ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 9 | ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 10 | Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 11 | Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 12 | Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 13 | Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 14 | Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| | **Гадаад валютын ханшийн эрсдэл** | | | |
| 15 | Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | 0.0% | Хангасан |
| | **Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд** | | | |
| 16 | Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 28.5% | Хангасан |
| 17 | Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 46.4% | Хангасан |
| | **Үндсэн хөрөнгийн үзүүлэлт** | | | |
| 18 | Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 1.0% | Хангасан |

Эх сурвалж: Бэрс Финанс ББСБ ХХК-ийн СЗХ-ны тайлан

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Андеррайтер:

MANDAL CAPITAL

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

## 3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Бэрс Финанс ББСБ ХХК нь өөрийн 100 хувийн эзэмшлийн Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК-ийг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулсан. Тус компани 2022 оны 06 сарын 22-ны өдрийн СЗХ-ны 355 тоот тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авснаар Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК болж өөрчлөгдсөн.

Ийнхүү Үнэт цаас гаргагч Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т "Баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-оос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулах эрхтэй", 11.1-д "Баталгаат үнэт цаасыг тусгай зориулалтын компани гаргана" гэж заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож байна.

Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК |
| Хувьцаа эзэмшил | Бэрс Финанс ББСБ ХХК /100 хувь/ |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2022.05.02 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011839153 |
| Регистрийн дугаар | 6862349 |
| Хаяг | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот |
| Утас | +976 9911-9632 |
| Цахим шуудан | otgonbat@bichilglobus.mn |
| Цахим хаяг | www.bers.abs.mn |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | 1,000,000 төгрөг |
| Нэрлэсэн үнэ | 1,000 төгрөг |
| Тоо ширхэг | 1,000 ширхэг |

## 3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр зохицуулна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид ХЭХ гэх/-ын бүрэн эрхийг толгой компани болох Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

### Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)

ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны журмыг баталж мөрдөнө. ТУЗ нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

Компанийн ХЭХ-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ шийдвэр гарснаас хойш 10-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-с баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр нөхөн сонгоно.

Компанийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

Компанийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах
- ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах
- Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх,
- Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих
- Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах,

СЗХ
2022 он 08 сар 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах,
- Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх,
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх

## Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь нийт 3 гишүүнээс бүрдэж байна. Үүнээс 2 гишүүн буюу ТУЗ-ийн нийт гишүүдийн 67 хувь нь хараат бус байна.



Баатар овогтой Болор-Эрдэнэ

ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн

**Боловсрол:**

2008-2012 он: Монгол Улсын Их Сургууль - Олон улсын эдийн засгийн харилцаа, магистр

2021 оноос одоог хүртэл: Монгол Улсын Их Сургууль - Олон улсын эдийн засгийн харилцаа, доктрант

**Ажлын туршлага:**

2006-2008 он: НҮБ-Хүн амын сан – Залуучуудын Зөвлөх Хорооны гишүүн

2008-2016 он: Голомт банк – Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн захирал

2016-2020 он: Баянгол Дүүрэг, Иргэдийн хурлын хурлын төлөөлөгч

2020 оноос одоог хүртэл: Мета Майнд ХХК – Гадаад харилцаа хариуцсан захирал



Самдан овогтой Отгонбат

ТУЗ-ийн гишүүн

**Боловсрол:**

2006-2010 он: Алтай коллеж – Компьютерийн техникийн инженер, бакалавр

2011-2013 он: Монгол Улсын Их Сургууль – Олон Улсын эдийн засгийн харилцаа, магистр

**Ажлын туршлага:**

2006-2007 он: Оргил Хотхон ХХК – Гүйцэтгэх захирал

2008-2009 он: Номин Холдинг ХХК – Ахлах менежер

2017 оноос одоог хүртэл: Бичил Глобус ХХК, Бэрс Финанс ББСБ ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS ҮЦК



Дашцэрэн овогтой Баатаржав

ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Боловсрол:**

2009-2013 он: СЭЗИС – Санхүү удирдлага, бакалавр
2017-2019 он: Бриджпорт Их Сургууль – Санхүүгийн шинжлэх ухаан, магистр

**Ажлын туршлага:**

2013-2016 он: Тэнгэр Капитал ҮЦК ХХК – Хөрөнгө оруулалтын шинжээч
2020-2021 он: Мандал Даатгал ХК – Хөрөнгө оруулалтын багцын менежер
2018 оноос одоог хүртэл: МЦ Констракшн ХХК – Санхүү хариуцсан захирал
2021 оноос одоог хүртэл: Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК – Ерөнхий захирал, Мандал Праявит Экуити Хувийн ХОС ХХК – Гүйцэтгэх захирал
2022 оноос одоог хүртэл: Монложистикс Холдинг ХХК – ТУЗ-ийн хараат бус гишүүн

### Гүйцэтгэх удирдлага

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу ТЗК нь хөдөлмөрийн гэрээний дагуу ажилтан авч ажиллуулж болохгүй тул Гүйцэтгэх удирдлага томилохгүй.

## 3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зориулалттай ТЗК-ийн хувьд эхлэлтийн санхүүгийн тайлан нь доорх байдалтай байна. Үүнд нийт хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК-аас шилжүүлсэн 10.3 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгө болон 1.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр хэмжигдэж байна.

Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Дүн, сая төгрөгөөр |
|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1 |
| Нийт зээл | 10,331 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **10,332** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 10,000 |
| Бусад өглөг | 331 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **10,331** |
| Хувьцаат капитал | 1 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **1** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **10,332** |

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

СЗХ
2022 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-08-15
БҮРТГЭВ-03

## 3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

### Санхүү байдлын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайланг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлтийг нэгтгэн дараах байдлаар төсөвлөсөн болно.

**Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр**

| Үзүүлэлт | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө | 1 | 1,498 | 2,819 | 4,344 | 990 | 2,706 | 4,363 | 5,760 | 1,919 |
| Нийт зээл | 10,331 | 9,489 | 8,542 | 7,356 | 5,998 | 4,528 | 3,067 | 1,809 | 740 |
| Хэвийн | | 8,930 | 8,084 | 6,989 | 5,713 | 4,316 | 2,921 | 1,719 | 697 |
| Анхаарал хандуулах | | 464 | 373 | 294 | 225 | 166 | 115 | 72 | 35 |
| Чанаргүй | | 95 | 85 | 74 | 60 | 45 | 31 | 18 | 7 |
| Эрсдэлийн сан | | (80) | (148) | (202) | (244) | (275) | (298) | (313) | (321) |
| **Нийт хөрөнгө** | **10,332** | **10,907** | **11,214** | **11,498** | **6,744** | **6,958** | **7,132** | **7,256** | **2,338** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 10,000 | 10,000 | 10,000 | 10,000 | 5,000 | 5,000 | 5,000 | 5,000 | - |
| Бусад өглөг | 331 | 795 | 703 | 624 | 556 | 497 | 446 | 403 | 366 |
| **Өр төлбөрийн дүн** | **10,331** | **10,795** | **10,703** | **10,624** | **5,556** | **5,497** | **5,446** | **5,403** | **366** |
| Хувьцаат капитал | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Хуримтлагдсан ашиг | - | - | 111 | 510 | 873 | 1,187 | 1,461 | 1,685 | 1,853 |
| Татварын дараах ашиг | - | 111 | 398 | 363 | 315 | 273 | 224 | 168 | 118 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **1** | **112** | **511** | **874** | **1,188** | **1,462** | **1,686** | **1,854** | **1,972** |
| **Өр төлбөр ба эзний өмч** | **10,332** | **10,907** | **11,214** | **11,498** | **6,744** | **6,958** | **7,132** | **7,256** | **2,338** |

**Эх сурвалж : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл**

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын болон орлогын тайлангийн төсөөллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлж буй зээлийн багцаас орох мөнгөн урсгал болон төлөвлөгдсөн зардалд үндэслэж боловсруулсан. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үндсэн төлбөрийг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойшхи 12 дах сард 50%-ийг төлөх тул тус хугацаанд буюу 4 дүгээр улиралд зээлийн хөрөнгө буурч байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссанаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22.1.1-д заасны дагуу татан буугдана. Санхүү байдлын тайлангийн төсөөллийн дагуу татан буулгах үед Үнэт цаас гаргагч нь 2.3 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байна. Үүнд 0.7 тэрбум төгрөг нь нийт зээл, 0.3 тэрбум төгрөг нь эрсдэлийн сан буюу 0.4 тэрбум төгрөг нь цэвэр зээл, 1.9 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 23-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь татан буугдсанаар энэхүү хөрөнгийг үүсгэн байгуулагч Бэрс Финанс ББСБ ХХК-д шилжүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТҮК ХХК
A8339 6862349
9022060933



МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC
ШТК0162 9021070414 5213487

СЗХ 2022 он 08 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-08-15 БО-ТГБ-03

## Орлогын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн хүүний орлого нь ТЗК руу шилжүүлсэн зээлийн хүүний орлогоос бүрдэнэ. Нөгөө талаас, Үнэт цаас гаргагчийн зардал нь ХБҮЦ-ны хүүний төлбөр, эрсдэлийн сан болон үйл ажиллагааны зардлаас бүрдэнэ.

Хүснэгт 13. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл

| Үзүүлэлтүүд | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүүний орлого | 1,090 | 1,034 | 978 | 908 | 651 | 565 | 483 | 410 |
| ХБҮЦ-ийн хүүний төлбөр | (420) | (420) | (420) | (420) | (210) | (210) | (210) | (210) |
| **Цэвэр хүүний орлого** | **670** | **614** | **558** | **488** | **441** | **355** | **273** | **200** |
| Эрсдэлийн сангийн зардал | (80) | (68) | (54) | (42) | (32) | (22) | (15) | (8) |
| **Эрсдэлийн сангийн дараах ашиг** | **590** | **546** | **504** | **446** | **410** | **333** | **258** | **192** |
| Үйл ажиллагааны зардал | (466) | (104) | (101) | (97) | (106) | (83) | (71) | (61) |
| **Татварын өмнөх ашиг** | **124** | **442** | **403** | **350** | **304** | **249** | **186** | **131** |
| Татвар | (12) | (44) | (41) | (35) | (31) | (25) | (19) | (14) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **111** | **398** | **363** | **315** | **273** | **224** | **168** | **118** |

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

## Зардлын төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/35 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үнэт цаас гаргагч нь хүүний болон үндсэн төлбөрийг Үнэт цаас эзэмшигчид олгохоос өмнө хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажлын хөлс, үйлчилгээ үзүүлэгчийн хөлс, хөндлөнгийн аудитын төлбөр, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлыг төлнө.

Хүснэгт 14. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал

| № | Зардлын зориулалт | Дүн | Давтамж |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр | Удирдаж буй хөрөнгийн нийт 0.75 хувь | Сар бүр |
| 2 | Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр | Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь | Сар бүр |
| 3 | Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр | 10 сая төгрөг | Жил бүр |
| 4 | ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал | Нийт 24 сая төгрөг, Улирал бүр 3 сая төгрөг | Улирал бүр |
| 5 | Зээлийн програм хангамжийн төлбөр | 18 сая төгрөг | Нэг удаа |

Эх сурвалж: : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК-ийн хооронд байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн бүхий л мөнгөн хөрөнгийг удирдах үүрэгтэй. Иймд тус үйлчилгээний төлбөр болгож Бэрс ХБҮЦ-ны үлдэгдлээс нэг удаа 0.75 хувиар тооцож ХБҮЦ төлөгдөх хугацаанд сар бүр хорогдуулан төлнө.

### Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/35 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үйлчилгээ үзүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын зээлийн эргэн төлөлтийг дараа сарын 25-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган төлбөр цуглуулах данс руу шилжүүлэх үүрэгтэй. Энэхүү үйлчилгээтэй төлбөр нь цуглуулсан төлбөрийн 2.5 хувьтай тэнцэнэ.

### ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардалд зориулж улирал бүр 3 сая төгрөг буюу үнэт цаасны хугацаанд 24 сая төгрөгийг олгохоор төлөвлөсөн.

### Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр

СЗХ-ны "ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 8.1-т заасны дагуу Үнэт цаас гаргагч нь жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэх шаардлагатай. Тус хүрээнд Үнэт цаас гаргагч нь Ниямазон Аудит ХХК-тай Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулсан. Тус гэрээний төлбөрт жилийн 10.0 сая төгрөгийг төлнө.

## Мөнгөн урсгалын төсөөлөл

Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл

| Үзүүлэлт | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүүний орох мөнгөн урсгал | 1,064 | 962 | 856 | 731 | 592 | 446 | 308 | 191 |
| Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал | 2,322 | 2,153 | 2,144 | 2,099 | 2,026 | 1,856 | 1,516 | 1,209 |
| ХБҮЦ-ны үндсэн төлбөр | - | - | - | (5,000) | - | - | - | (5,000) |
| ХБҮЦ-ны хүүний төлбөр | (420) | (420) | (420) | (420) | (210) | (210) | (210) | (210) |
| Үйл ажиллагааны зардал | (466) | (104) | (101) | (97) | (106) | (83) | (71) | (61) |
| Татварын зардалд төлсөн төлбөр | (12) | (44) | (40) | (35) | (30) | (25) | (19) | (13) |
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **2,487** | **2,547** | **2,439** | **(2,721)** | **2,271** | **1,982** | **1,523** | **(3,884)** |

СЗХ 2022.08 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

2022-08-15 БҮРТГЭВ-03

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хадгаламж, хөрөнгө оруулалтын хүүний орлого[3] | 26 | 72 | 122 | 177 | 59 | 120 | 174 | 219 |
| *Банкны хадгаламж* | *5* | *14* | *24* | *34* | *11* | *23* | *34* | *43* |
| *Үнэт цаасны хөрөнгө оруулалт* | *8* | *23* | *39* | *57* | *19* | *39* | *56* | *71* |
| *Итгэлцэл* | *12* | *35* | *59* | *86* | *29* | *58* | *84* | *106* |
| Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт | (1,016) | (1,298) | (1,036) | (810) | (614) | (446) | (301) | (177) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **(990)** | **(1,225)** | **(914)** | **(633)** | **(555)** | **(326)** | **(127)** | **42** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1 | 1,498 | 2,819 | 4,344 | 990 | 2,706 | 4,363 | 5,760 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,498 | 2,819 | 4,344 | 990 | 2,706 | 4,363 | 5,760 | 1,919 |
| **(Харилцах+Зээл)/ ХБҮЦ** | **110%** | **114%** | **117%** | **140%** | **145%** | **149%** | **151%** | **n/a** |

**Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл**

## 3.5 ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

### Төлбөр цуглуулах данс

ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. Тус дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь хөрөнгө итгэмжлэн удирдагч компани байна.

### Зээлийн эргэн төлөлтийн данс

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Тус дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч байна.

### Хадгаламжийн данс

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг хадгаламжийн дансанд байршуулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр

[3] ТЗК-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд буюу 30%-ийг банкны хадгаламжид дунджаар сарын 0.75%-ийн хүүтэй, 30%-ийг үнэт цаасанд дунджаар сарын 1.25%-ийн хүүтэй, 40%-ийг ББСБ-ийн итгэлцлийн үйлчилгээнд дунджаар сарын 1.4%-ийн хүүтэйгээр тус тус байршуулан хүүний орлого олохоор төлөвлөсөн.

УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

гүйцэтгэх данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй. Тус хадгаламжийн данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр гүйцэтгэх данс руу зарлага гаргах боломжтой.

**Үнэт цаасны данс**

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг хөрвөх чадвартай үнэт цаасад байршуулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд үнэт цаасыг зарж, мөнгөн үлдэгдлийг төлбөр гүйцэтгэх данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй. Тус үнэт цаасны данснаас ТЗК-ийн байгуулсан төлбөр гүйцэтгэх данс руу зарлага гаргах боломжтой.

**Итгэлцлийн данс**

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг ББСБ-ын итгэлцэлд байршуулна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд итгэлцлийг цуцалж, мөнгөн үлдэгдлийг төлбөр гүйцэтгэх данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй. Тус итгэлцлийн харилцах данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр гүйцэтгэх данс руу зарлага гаргах боломжтой байна.

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Андеррайтер:

MANDAL CAPITAL

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

## 4.1 ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ

Бэрс ХБҮЦ-ыг зах зээлд санал болгох, үнэт цаасжуулах хэлцэлд Үнэт цаас гаргагчаар Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагчаар Бэрс Финанс ББСБ ХХК, Андеррайтераар Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК, Хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргагчаар Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН, Зээлийн шинжилгээ гаргагчаар Онч Аудит ХХК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар Юнайтед Айр Файнэнс ХХК нар ажилласан. Үнэт цаасжуулах хэлцэл нь дараах байдалтай байна.

Схем 1. Үнэт цаасжуулах хэлцэл




### Тусгай Зориулалтын Компани байгуулах

ТЗК нь баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Бэрс Финанс ББСБ ХХК нь автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан.

### Үнэт цаасжуулах зээлийн /хөрөнгийн/ багцыг сонгон шалгаруулах

Хөрөнгийн багцад ТУЗ-с баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгүүд багтсан. Уг шалгуур үзүүлэлтүүдийг хөндлөнгийн санхүүгийн болон хуулийн шинжээч нараар давхар баталгаажуулан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан хөрөнгийг ТЗК руу шилжүүлнэ.

**Багцад багтсан хөрөнгүүд шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах**

Хөрөнгийн багцын шалгуурын дагуу ХБҮЦ-ны зээлийн хөрөнгө хуулийн болон санхүүгийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн шинжилгээг Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН, зээлийн шинжилгээг Онч Аудит ХХК боловсруулсан.

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК руу хөрөнгө шилжүүлэх**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гэрээ үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно.

**Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх**

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ.

**Анхдагч зах зээлийн захиалгыг зохион байгуулах**

Зохицуулагч байгууллагуудаас зөвшөөрөл олгогдсоны дараа Андеррайтер нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг зохион байгуулж, бирж төвтэй анхдагч зах зээлийн захиалгыг хүлээн авч гүйцэтгэнэ.

**Хөрөнгө оруулагчид үнэт цаас худалдаж авах**

Үнэт цаасны захиалга нээгдэх хугацаанд үнэт цаас эзэмших хүсэлтэй хөрөнгө оруулагчид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх үнэт цаасны дансанд мөнгийг байршуулж, захиалгыг хийж гүйцэтгэнэ. Захиалга биелснээр үнэт цаас хөрөнгө оруулагчийн эзэмшилд шилжиж, үнэт цаасны танилцуулгад заасан төлбөрийн хуваарийн дагуу хүүний болон үндсэн төлбөрийг хүлээж авна.

**Хөрөнгийг удирдах**

Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгөтэй холбоотой бүртгэх, тайлагнах болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үнэт цаасны хугацааны турш үзүүлнэ.

**ТЗК татан буугдах**

Баталгаат үнэт цаастай холбогдсон үүрэг дуусгавар болмогц ТЗК нь татан буугдана.

## 4.2 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний шинж чанарын хувьд хадгаламж, Засгийн газрын үнэт цаас, компанийн нээлттэй болон хаалттай бондтой харьцуулагдах боломжтой.

Монгол Улсын Засгийн Газрын үнэт цаас нь дотоодын зах зээлд арилжаалагддаггүй, хаалттай бонд нь мэргэжлийн буюу хязгаарлагдмал хөрөнгө оруулагчдад зориулсан тул Бэрс ХБҮЦ-ны хүүний түвшинг банкны хадгаламж болон компанийн нээлттэй бонд, ХБҮЦ-ийн хүүтэй харьцуулах замаар тогтоосон.

Бэрс ХБҮЦ-ны хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс хүүний түвшинг 1) макро эдийн засгийн орчинтой уялдуулж, инфляцын түвшнээс өндөр буюу мөнгөний үнэ цэнийг алдагдуулахгүй байхаар 2) банкны хадгаламжаас өндөр байхаар тогтоосон. Тус үндэслэлээр Бэрс ХБҮЦ-ны хүүний түвшинг 16.8 хувиар тодорхойлсон.

### Инфляцын түвшинтэй харьцуулахад

2022 оны 05-р сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд инфляцын түвшин 15.1 хувь, шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 7.9 хувь, системийн нөлөө бүхий Топ-5 банкны 24 сарын хугацаатай хадгаламжийн дундаж хүү 9.8 хувь байна.

Иймд хөрөнгө оруулагчид мөнгөний үнэ цэнийг алдагдуулахгүйгээр өгөөж хүртэхийн тулд 15.1 хувиас дээш түвшинд хөрөнгө оруулалт хийх шаардлага үүсээд байна. Бэрс ХБҮЦ-ны хүү болох 16.8 хувь нь хөрөнгө оруулагчдыг инфляцын эрсдэлээс хамгаалах түвшинд байна.

Зураг 20. Инфляц ба хадгаламжийн хүүний түвшин, хувиар




Эх сурвалж: Монголбанк

## Банкны хадгаламжтай харьцуулахад

2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар банкны системийн нөлөө бүхий топ-5 банкны 24 сарын хугацаатай хадгаламжийн хүү 9.0-10.2 хувийн түвшинд хэлбэлзэж, дунджаар 9.8 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс ХБҮЦ-ны хүүний түвшин нь тус дундаж хүүнээс 7.0 нэгж хувиар буюу 1.7 дахин өндөр байна.

Зураг 21. Системийн нөлөө бүхий топ-5 банкны хадгаламжийн хүү, хувиар




Эх сурвалж: Банкуудын цахим хуудас

## ХБҮЦ болон нээлттэй бондтой харьцуулахад

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй хүрээнд Инвескор ББСБ ХК, ЛэндМН ББСБ ХК, МобиФинанс ББСБ ХХК болон Эрдэнэс Тавантолгой ТӨХК-ийн бонд, Инвескор Актив ТЗК ХХК болон Омни Актив ТЗК ХХК-ийн ХБҮЦ арилжаалагдаж байна.

Үүнээс дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй нээлттэй бондын дундаж хүүний түвшин 12.8 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс ХБҮЦ-ны хүүний түвшин нь нээлттэй бондын дундаж хүүнээс 4.0 нэгж хувиар буюу 1.3 дахин өндөр байна.

Дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй Инвескор Актив ХБҮЦ 14.4 хувь, Омни Актив ХБҮЦ 14.5 хувийн хүүтэй буюу зах зээл дэх ХБҮЦ-ны дундаж хүү 14.45 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Бэрс ХБҮЦ-ны хүүний түвшин нь энэхүү дундаж хүүний түвшнээс 2.3 нэгж хувиар буюу 1.2 дахин өндөр байна.

Зураг 22. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны хүү, хувиар




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## 4.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Бэрс ХБҮЦ нь хөрөнгө оруулагч нарт хүүний төлбөрийг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойшхи улирал тутам олгохоор шийдвэрлэсэн.

Хүснэгт 16. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр

| Улирал | Анхны хөрөнгө оруулалт | Хүүгийн орлого /татварын өмнөх/ | Хүүгийн орлого /татварын дараах (5%)/ | Үндсэн төлбөр | Хугацааны эцэст хүү болон үндсэн төлбөр |
|---|---|---|---|---|---|
| 0 | (100,000) | | | | |
| 1 | | 4,200 | 3,990 | - | 3,990 |
| 2 | | 4,200 | 3,990 | - | 3,990 |
| 3 | | 4,200 | 3,990 | - | 3,990 |
| 4 | | 4,200 | 3,990 | 50,000 | 53,990 |
| 5 | | 2,100 | 1,995 | - | 1,995 |
| 6 | | 2,100 | 1,995 | - | 1,995 |
| 7 | | 2,100 | 1,995 | - | 1,995 |
| 8 | | 2,100 | 1,995 | 50,000 | 51,995 |
| **Нийт** | **(100,000)** | **25,200** | **23,940** | **100,000** | **123,940** |

Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Үнэт цаасад хөрөнгө оруулагч нь 100 мянган төгрөгөөр 1 ширхэг ХБҮЦ-д хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд үнэт цаасны хугацааны эцэст буюу 24 сарын дараа татварын өмнөх байдлаар 25.2 хувь, татварын дараах байдлаар 23.94 хувийн өгөөж хүртэхээр байна. Үүнд үнэт цаас эзэмшсэнээс хойшхи эхний 12 сарын хугацаанд татварын өмнөх байдлаар 16.8 хувь, татварын дараах байдлаар 15.96 хувийн өгөөж хүртэхээр байна.

СЗХ
2022.08.10 он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

## 4.4 ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

### Төлбөрийн хуваарь, аргачлал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/33 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрийг тооцож олгоно. Үүнд анхдагч зах зээлийн захиалга амжилттай явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Үндсэн төлбөр болон хүүний төлөлтийг дараах аргачлалын дагуу хөрөнгө оруулагчид олгоно.

Хүснэгт 17. Төлбөрийн хуваарь ба аргачлал

| | |
|---|---|
| Хүү тооцож эхлэх хугацаа | Хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдөр |
| Хүү төлөх давтамж | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш улирал тутам |
| Хүүний төлбөр тооцох аргачлал (татварын өмнө) | $\frac{\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ} * (16.8\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар}$ |
| Хүүний төлбөр тооцох аргачлал (татварын дараа) | $\frac{\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ} * (15.96\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар}$ |
| Үндсэн төлбөр төлөх давтамж | Үнэт цаасны хугацааны 12 дахь сард болон хугацааны эцэст тэнцүү төлөлттэй. |
| Үндсэн төлбөр тооцох аргачлал | Үнэт цаас эзэмшиж эхэлсэн огноо + 12 сар /50%/<br>Үнэт цаас эзэмшиж эхэлсэн огноо + 24 сар /50%/ |
| Нийт төлөгдөх дүн | $\text{Үндсэн төлбөр} + \frac{\text{Хүү тооцох дүн}^{4} * (15.96\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар} * 8 \text{ удаа}$ |

Эх сурвалж: Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам

### Төлбөрийн дараалал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/35 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-н дагуу Үнэт цаас гаргагчийн төлбөр төлөх дараалал нь дараах байдалтай байна.

[4] Үндсэн төлбөрийн үлдэгдлээс тооцно.



БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

1. ТЗК-ийн татварын төлбөр
2. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн шимтгэл, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал
3. Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал
4. Аудитын үйлчилгээний төлбөр
5. ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн цалин
6. Үнэт цаасны хүүгийн төлбөр
7. Үнэт цаасны үндсэн төлбөр
8. Бусад зардал

## Төлбөрийн график

Хүснэгт 18. Төлбөрийн график, сая төгрөгөөр

| Огноо | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал | VII улирал | VIII улирал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үнэт цаасны үлдэгдэл | - | 10,000 | 10,000 | 10,000 | 5,000 | 5,000 | 5,000 | 5,000 | - |
| Үндсэн төлбөрийн төлөлт | - | - | - | - | (5,000) | - | - | - | (5,000) |
| Хүүний төлбөрийн төлөлт | - | 420 | 420 | 420 | 420 | 210 | 210 | 210 | 210 |

Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжүүлсэн 10.3 тэрбум төгрөгийн үнийн дүн хүртэлх дүн бүхий автомашины фидуци бүхий зээлийн багцаас орж ирэх зээлийн үндсэн төлбөр болон хүүний төлбөрөөс бүрдэнэ.

# 4.5 ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ

Бэрс ХБҮЦ-ны хөрөнгөд 1,188 зээлдэгчийн 10,330,821,621 төгрөгийн үлдэгдэл бүхий 1,186 зээлийн гэрээг багцалсан болно.

Хүснэгт 19. Багцын тойм

| Багцын үндсэн үзүүлэлтүүд | |
|---|---|
| Нийт зээлийн үлдэгдэл, төгрөг | 10,330,821,621 |
| Нийт анх олгосон дүн, төгрөг | 12,955,290,300 |
| Зээлийн гэрээний тоо | 1,188 |
| Зээлдэгчийн тоо | 1,186 |
| Зээлийн дундаж үлдэгдэл, төгрөг | 8,695,978 |
| Зээлийн төрөл | Автомашины зээл |

| Зээлийн төвлөрөл | |
|---|---|
| Хамгийн их дүнтэй 1 зээлийн нийт багцад эзлэх хувь | 0.53% |
| Хамгийн их дүнтэй 10 зээлийн нийт багцад эзлэх хувь | 3.54% |
| Хамгийн их дүнтэй 50 зээлийн нийт багцад эзлэх хувь | 12.93% |
| **Жигнэсэн дундаж үзүүлэлт** | |
| Жигнэсэн дундаж хүү /сар/ | 3.2% |
| Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа /сар/ | 31.3 |
| Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа /сар/ | 25.9 |
| Жигнэсэн дундаж LTV | 50.1% |
| Багцын зээлийн чанар | 100% хэвийн зээл |

**Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл**

Тус зээлийн хөрөнгийн багцад нийт хөрөнгийн 20 болон түүнээс дээш хувийг дангаар болон холбоотой этгээдтэй хамтран эзлэх үүрэг гүйцэтгэгч байхгүй болно. Тодруулбал, хамгийн их дүнтэй зээл нь нийт багцын үлдэгдлийн 0.53 хувийг эзэлж буй нь үнэт цаасжуулсан зээлийн багц хөрөнгө нь төвлөрөл маш багатайг илэрхийлж байна.

## Зээлийн багцын шалгуур

Бэрс ХБҮЦ-ны зээлийн багц нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

**Хүснэгт 20. Хуулийн шаардлага хангасан байдал**

| Хуулийн заалт | Хангагдсан эсэх |
|---|---|
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ | Үнэт цаас гаргагч нь 10.0 тэрбум төгрөгийн дүнтэй үнэт цаасыг, 10.3 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн багцаар баталгаажуулсан. |
| Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө байна. | Зээлийн багц нь гэрээний үндсэн дээр Бэрс Эй Би Эс Актив руу бүрэн шилжсэн. |
| Хөрөнгийн багцад дараахь хөрөнгийг оруулахыг хориглоно:<br>- дуусаагүй барилга, сул чөлөөтэй газрын барьцаа;<br>- зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хуульд заасан эрх бүхий этгээдээс тогтоосон хэмжээнээс хэтэрсэн барьцаат зээл;<br>- хугацаа хэтэрсэн хөрөнгө | Зээлийн багц нь 100 хувь хэвийн ангилалтай автомашины фидуци бүхий зээлийн хөрөнгөөс бүрдсэн. |

**Эх сурвалж : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл**

Бэрс ХБҮЦ-ны зээлийн багцын шалгуур үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/33 тоот тогтоолоор батлсан. Зээлийн багцыг санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийн дагуу нийт зээлийн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгож, зээлийн шинжилгээ гаргагч Онч Аудит ХХК болон хуулийн дүгнэлт гаргагч Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН-ээр хөндлөнгийн тайлан гаргуулсан.

## Зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур

- Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;
- Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;
- Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;
- Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;
- Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

## Зээлдэгчид тавигдсан санхүүгийн шалгуур

- СЗХ-нд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;
- Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;
- Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;
- Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх);
- Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;
- Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх;
- Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 55%-с илүүгүй байх;

СЗХ
2022 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-15
БҮРТГЭВ-03

ӨОХ = зээлийн сарын төлбөр / (Өрхийн сарын орлого (татвараас өмнөх))

- Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-с хэтрэхгүй байх

  ЗҮХ = (Тасалбар болгох өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн үлдэгдэл) / (Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ);
- Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх;
- Үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн албан хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байх.

## Зээлийн шинжилгээ гаргагчийн дүгнэлт

Онч Аудит ХХК нь шалгуурын дагуу сонгогдсон зээлийн багцад багтах зээлүүдээс түүвэрлэж, түүвэрт орсон зээлүүд нь санхүүгийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнд санамсаргүй түүврийн аргаар сонгон авсан 119 зээлийн зээлдэгчийн хувийн хэрэг, цахим зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга, Төрийн цахим мэдээллийн сангийн лавлагаа, Зээлийн мэдээллийн сан зэрэг нийт 6 санхүүгийн шалгуур үзүүлэлтээр мэдээллийг шалгасны үр дүнгээр дүгнэсэн.

Онч Аудит ХХК нь 1-5 дугаар шаардлагын хувьд бүх шалгуурыг хангаж байгаа гэж дүгнэсэн. 6 дугаар шалгуурын хувьд 8 зээлдэгчээс бусад зээлдэгчийн өр орлогын харьцаа 55%-с хэтрээгүй байна гэж дүгнэсэн бөгөөд шалгуур хангаагүй 8 зээлийг Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК-д шилжүүлсэн зээлийн багцаас хассан.

## Хөндлөнгийн хуулийн дүгнэлт

Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН нь автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээлийн данснуудаас санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн данснуудад хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж гүйцэтгэж, тус шинжилгээний үр дүнгээр санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 54 (тавин дөрөв) зээлийн данснуудын зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр, аливаа эрсдэл үүсээгүй гэж дүгнэсэн.

## Зээлийн багцын төвлөрөл

Хүснэгт 21. Зээлийн багц, дүнгээр

| Анх олгосон дүн | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн (сая.төг) | % |
| 0 – 10 сая | 665 | 56.0% | 3,751 | 29.0% |
| 10 – 15 сая | 211 | 17.8% | 2,699 | 20.8% |
| 15 – 20 сая | 209 | 17.6% | 3,727 | 28.8% |
| 20 – 30 сая | 85 | 7.2% | 2,057 | 15.9% |
| 30 – 60 сая | 18 | 1.5% | 722 | 5.6% |
| **Нийт** | **1,188** | **100.0%** | **12,955** | **100.0%** |

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

ХБҮЦ-ны зээлийн багцад хамгийн их дүнтэй зээл 0.53 хувь, хамгийн их дүнтэй 10 зээл 3.54 хувь, хамгийн их дүнтэй 50 зээл 12.93 хувийг тус тус эзэлж буй нь зээлийн багцын төвлөрөл бага болохыг харуулж байна. Хамгийн бага дүнтэй нь анх 1.0 сая төгрөгөөр олгогдсон зээл байна.

Нийт багцад багтсан 1,188 зээлийн 665 буюу 56.0 хувь нь 10.0 сая төгрөгөөс доош дүнтэй, 17.8 хувь нь 10.0-15.0 сая төгрөг, 17.6 хувь нь 15.0-20.0 сая төгрөг, 7.2 хувь нь 20.0-30.0 сая төгрөг, 1.5 хувь нь 30.0-60.0 сая төгрөгийн үнийн дүнтэй зээл байна.

## Зээлийн багцын хугацаа

Хүснэгт 22. Зээлийн багц, хугацаагаар

| Зээлийн анхны хугацаа (сар) | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн (сая.төг) | % |
| 3 – 9 | 7 | 0.6% | 134 | 1.0% |
| 10 - 12 | 59 | 5.0% | 415 | 3.2% |
| 13 - 20 | 34 | 2.9% | 206 | 1.6% |
| 21 - 24 | 572 | 48.1% | 4,224 | 32.6% |
| 33 - 36 | 468 | 39.4% | 7,272 | 56.1% |
| 47 - 48 | 48 | 4.0% | 704 | 5.4% |
| **Нийт** | **1,188** | **100.0%** | **12,955** | **100.0%** |

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл

Багцын зээлийн дүнгийн 48.1 хувь нь 21-24 сарын хугацаатай зээл, 39.4 хувь нь 33-36 сарын хугацаатай зээл байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хугацаа нь 24 сарын хугацаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байгаа тул багцын хөрөнгийн хугацаатай уялдаатай байх нь зээлийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгал болон үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрт төлөгдөн гарах мөнгөн урсгалтай нийцэж байх, улмаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлдэг.

Зээлийн багцын жигнэсэн дундаж хугацаа 31.3 сар байгаа нь үнэт цаасны хугацаа болох 24 сараас урт хугацаатай буюу үнэт цаасны хугацааны турш үндсэн болон хүүний төлбөрийг төлөх мөнгөн урсгал хангагдах боломжтойг илэрхийлж байна.

## Зээл олгогдсон огноо

Хүснэгт 23. Зээлийн багц, улирлаар

| Анх олгосон огноо | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| 2019-2020 | 8 | 0.7% | 80.15 | 0.6% |
| 2021 I | 12 | 1.0% | 92 | 0.7% |
| 2021 II | 70 | 5.9% | 456 | 3.5% |
| 2021 III | 213 | 17.9% | 1,316 | 10.2% |
| 2021 IV | 363 | 30.6% | 3,794 | 29.3% |
| 2022 I | 444 | 37.4% | 6,148 | 47.5% |
| 2022 II | 78 | 6.6% | 1,069 | 8.3% |
| **Нийт** | **1,188** | **100.0%** | **12,955** | **100.0%** |

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ



Зээлийн багцын 37.4 хувь нь 2022 оны 1 дүгээр улиралд олгогдсон зээл, 30.6 хувь нь 2021 оны 4 дүгээр улиралд олгогдсон зээл байна. Нийт зээлийн багцын 86 хувь нь сүүлийн 9 сард олгогдсон буюу шинэ зээлүүд байна.

## Зээлийн хүүний түвшин

**Хүснэгт 24. Зээлийн багц, хүүний түвшнээр**

| Хүүгийн тархалт | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| 2.3% - 3.0% | 318 | 26.8% | 5,347 | 41.3% |
| 3.2% - 3.5% | 567 | 47.7% | 5,988 | 46.2% |
| 3.7% - 4.9% | 303 | 25.5% | 1,621 | 12.5% |
| **Нийт** | **1,188** | **100.0%** | **12,955** | **100.0%** |

**Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл**

Багцад багтсан зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 3.2 хувь байна. Үүнд автомашины зээлийн багцын дүнгийн 47.7 хувь нь сарын 3.2-3.5 хувь, 25.5 хувь нь сарын 3.7-4.9 хувь, 26.8 хувь нь сарын 2.3-3.0 хувь байна. Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны сарын хүү 1.4 хувь буюу хөрөнгийн багцын зээлийн жигнэсэн дундаж хүү болох 3.2 хувиас бага байна. Энэ нь зээлийн хүүний орлого нь үнэт цаасны хүүний төлбөрийг төлөхөд хүрэлцээтэй болохыг харуулж байна.

## Зээлийн чанар

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 06 сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолын дагуу зээлийн багцад ямар нэг хугацаа хэтрэлт, чанаргүйдэлт үүсээгүй, 100 хувь хэвийн байх санхүүгийн шалгуурыг тавьсан. Иймд үнэт цаасжуулсан зээлийн багц нь 100 хувь хэвийн хэвийн ангилалтай буюу зээлийн чанар сайн байна.

## Зээлийн барьцаа хангалт (LTV)

Нийт зээлийн багцын тоогоор 69 хувийг барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа (LTV) 55 хувиас бага зээлүүд эзэлж байгаа ба багцын жигнэсэн дундаж LTV харьцаа 50.1 хувь байна. Нийт барьцааны дүн 25.6 тэрбум төгрөг байгаа нь нийт зээлийн багцын үлдэгдлээс 2.5 дахин их үзүүлэлт бөгөөд энэ нь нийт багцын барьцаа хөрөнгийн хэмжээ хангалттай өндөр түвшинд байгааг илэрхийлж байна.

**Хүснэгт 25. Зээлийн багцын барьцаа, LTV харьцаа**

| LTV харьцаа | Зээлийн тоогоор | Зээлийн тоогоор багцад эзлэх хувь | Зээлийн багцын дүн | Зээлийн дүнгээр багцад эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 0-40% | 656 | 55% | 3,167 | 31% |
| 41%-55% | 165 | 14% | 1,837 | 18% |
| 56%-65% | 232 | 20% | 3,178 | 31% |
| 65%-75% | 135 | 11% | 2,148 | 21% |
| **Нийт** | **1,188** | **100%** | **10,330** | **100%** |

**Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл**



УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТҮЦ ХХК
МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -08- 15

### Багцын дүгнэлт

Зээлийн багцын дүнгийн 48.1 хувийг 21-24 сарын хугацаатай, 56.0 хувийг 0.0-10.0 сая төгрөгөөр олгогдсон зээл эзэлж байна. Нийт зээлийн багцын 86 хувь нь сүүлийн 9 сард олгогдсон буюу шинэ зээлүүд байна. Үүнээс дүгнэхэд зээлийн багц нь төвлөрөл багатай, шинээр олгогдсон 100 хувь хэвийн ангилалтай автомашины зээлээс зээлүүдээс бүрдсэн.

## 4.6 ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/35 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-д заасан дараах үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.

Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, солих замаар багцаас хасна. Үүнд:

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагчаас үзсэн;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хөрөнгө худалдах худалдан авах гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн.
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хэтэрсэн;

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах



ЭРС БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

## 4.7 ТАТАН БУУГДАХ, ХӨРӨНГИЙГ ДАХИН ҮНЭЛЭХ НӨХЦӨЛ

Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК-ийн компанийн дүрмийн 8 дугаар зүйлд зааснаар ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана. ТЗК-ийг татан буулгах шийдвэрийг гаргах этгээд нь ТЗК/1/ эсхүл үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч/2/ эсхүл СЗХ-ны хүсэлтийг үндэслэн шүүх/3/ байна.

1. Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
2. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан;
3. Баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан;
4. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

Бэрс ХБҮЦ нь 24 сарын хугацаатай, нөгөө талаас зээлийн урьдчилан төлөлт өндөр байдаг тул барьцаа хөрөнгийг дахин үнэлэхгүй болно. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр №22/21а/35 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-ын 2.3.2, 2.3.3-т заасны дагуу хөрөнгийн багц дахь зээл нь "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-нд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн буюу шалгуур үзүүлэлт хангахгүй болсон эсхүл зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хугацаа хэтэрсэн тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцогдож, тус зээлийн хөрөнгийг багцаас хасаж, шаардлага хангах хөрөнгөөр сольж бүртгэнэ.

Тус журмын 2.5.1-д заасны шаардлага хангахгүй хөрөнгийг шаардлага хангах хөрөнгөөр солих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд тус хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдахаар зохицуулсан. Иймд үнэт цаасны хугацаанд

СЗХ
он сар өдөр
2022 08 10
БҮРТГЭВ



2022-08-15
БҮРТГЭВ-03

ТЗК-ийн хөрөнгийн багц нь хэвийн ангилалтай, шалгуур хангах зээлүүдээс бүрдэх тул ТЗК-ийн хөрөнгийг дахин үнэлэх шаардлага үүсэхгүй болно.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.7-д зааснаар "Тусгай зориулалтын компанийн хувьцаа эзэмшигч нь СЗХ-ны зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжах, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно." гэж заасны дагуу нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах хэлбэрээр өөрчлөн байгуулах тохиолдолд СЗХ-с зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

## 4.8 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаасжуулах ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хөрөнгийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлого тасалдах эрсдэл бий болж болзошгүй байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №22/21а/33 тоот тогтоолоор "Эрсдэлийн удирдлагын журам"-ыг баталсан.

Үнэт цаасжуулах үйл ажиллагааны хүрээнд дараах эрсдэлүүд учирч болзошгүй. Үүнд:

- Зээлтэй холбоотой эрсдэл
- ХБҮЦ гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл
- Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл

**Зээлтэй холбоотой эрсдэл**

- Зээлийн эрсдэлд зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, Зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.
- Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэлд зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.

**Зээлтэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг СЗХ-с баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-г мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.
- Эрсдэлийн сан байгуулах ТЗК нь хагас жил тутамд зээлийн эрсдэлийн санг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) 9-н дагуу тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.
- ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.
- ТЗК нь зээл хугацаагаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ХК ХХК



МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.

## Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл

### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлэх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болох
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдах эрсдэлийг ойлгоно.

### Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийн удирдлага

- Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө ТЗК-ийн "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-н 3.3.1.1 дэх хэсэгт заасан эрсдэл үүсэх тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
- ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан.

### Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх
- Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.

### Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийн удирдлага

- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана.
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйл ажиллагааг цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг арилгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой

тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.

- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.
- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.
- ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл**

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийн удирдлага**

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч компаниудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно. Түүнчлэн ХБҮЦ нь олон

тооны бага дүнтэй зээлээс бүрдсэн тул зээлийн багцын орох урсгал болон үнэт цаасны төлөлтийн хяналтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь програм ашиглан өдөр тутам хэрэгжүүлнэ.

**Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл**

- ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэлийг ойлгоно.

**Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.
- Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана.
    - Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан давагдашгүй хүчин зүйлийг, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.
    - Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ч үндсэн үүргээс чөлөөлөхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

**Эргэн төлөлтийг сайжруулах**

ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээг авна.

- Багцын хөрөнгийг сайжруулах, солино.
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.
- Багцын хөрөнгийн дүнг ХБҮЦ-ны төлбөрийн төлөгдөөгүй дүнгийн 110 хувиас багагүй байлгана.
- Эрсдэлийн сан байгуулна.
- Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад нь ангид байлгана.
- ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журмын 3.3.6 дугаар зүйлийн 3.3.6.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулна.
- ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлнэ.
- ТЗК нь татан буугдах үед зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

СЗХ
2022.08.10
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Андеррайтер:

MANDAL CAPITAL

Таны хувийн банкир

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS ҮЦК

## 5.1 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаа нь хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна Үүнд:

- Иргэний хууль
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- Зээлийн мэдээллийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
- Коронавирусt халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

**Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд**

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
- Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам
- Үнэт цаас зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам
- Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам

**Монголын Хөрөнгийн биржийн журмууд**

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлийн журам
- Арилжааны журам
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам

**Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн журмууд**

- Үнэт цаасны хадгаламжийн журам
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам

СЗХ 2022 он 08 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

Bers ABS active

2022-08-15

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа нь Банк бус санхүүгийн байгууллага болохын хувьд хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна.

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын Олон гэрээ конвенцийг соёрхон батлах тухай /Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенц/
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн , ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар, болон агаараар хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах туай /Палермогийн конвенц/
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт хийх журам
- Бэрс Финанс ББСБ ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл
- Компанийн засаглалын кодекс
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам

**Хөрөнгийн багцтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон байдаг.

Дээрхээс үзвэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүнийг гаргагчтай холбоотой эрх зүйн үндсийг тогтож байгаа эрх зүйн гол баримт бичиг нь энэ хууль болох бөгөөд уг хуулиар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд танигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат үнэт цаас



БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

гаргах харилцаанд оролцогч этгээдүүдийн хоорондын харилцаа, эрх үүрэг болон хөрөнгө оруулагчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтууд бүгд тусгагдсан байна. Дээрх хуульд үндэслэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон, үнэт цаасыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулагч байгууллага болох МХБ, СЗХ-оос гаргасан журмуудаар зохицуулж байна.

СЗХ-ны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам" -ын 1.1-д "Энэхүү журмын зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгэх, түүнд хяналт тавих, зэх зээлийн харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон түүнийг бүртгэх, оролцогчдод тавих шалгуурыг тогтоох, эрх олгохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан байна.

Мөн энэхүү журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч хуулийн этгээдтэй холбоотой Компанийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй асуудлууд болох үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, Бүртгэлийн шалгуур шаардлага тогтоох, Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд биржээс хяналт тавих журмыг тогтоосон байна.

## 5.2 ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ ЖУРМУУД

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр №22/21а/35 тоот тогтоолоор баталсан.

**Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам**

Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

**Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам**

Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

**Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам**

Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам**

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан.

**Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам**

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.

**Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам**

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.

**Эрсдэлийн удирдлагын журам**

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан.

СЗХ
он сар өдөр
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

2022 -08- 15
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Андеррайтер:

MANDAL CAPITAL

MANDAL CAPITAL MARKETS

# 6.1 ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1 болон 12.2-т зөвхөн СЗХ-ны нийтэд санал болгохыг хүлээн зөвшөөрсөн, мөн МХБ-ийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг анхдагч зах зээлээр арилжихыг заасан байдаг.

Улмаар ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" (2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 9 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан), мөн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д (ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан) заасны дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн "ХБҮЦ-ны бүртгэлийн журам"-д заасан шалгуурын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд ХБҮЦ-г санал болгон арилжаална. Тус үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болно.

ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн захиалгыг зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд явуулах ба захиалгын дүн 10.0 тэрбум төгрөгт хүрсэн тохиолдолд арилжааг амжилттай болсонд тооцож арилжааг хаана.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд дараах үйл явцын дагуу санал болгоно:

1. ТЗК байгуулах
2. Үнэт цаасыг эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх
3. Олон нийтэд санал болгох
4. Захиалгын бүртгэл хийх
5. Захиалгыг баталгаажуулан үнэт цаасны нийлүүлэлт хийх
6. Үнэт цаасыг эзэмшүүлж төлбөр тооцоог гүйцэтгэх
7. Хоёрдогч арилжааг эхлүүлэх

СЗХ 2022 он 08 сар 10 өдөр БҮРТГЭВ № 06

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-08-15 БҮРТГЭВ-03

## 6.2 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд СЗХ-ноос зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн бирж-д бүртгэлтэй 54 үнэт цаасны компаниар дамжуулан оролцох боломжтой.

Зураг 23: Үнэт цаасны арилжаанд оролцох заавар

| 1 | 2 | 3 |
|---|---|---|
| **Үнэт цаасны данс нээлгэх** | **Мөнгө байршуулах** | **Захиалга өгөх** |
| МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компаниудаас сонгон дансаа нээх | Брокероос өөрийн үнэт цаасны дансанд мөнгө байршуулах заавар авах, байршуулах | Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа үнэт цаас худалдан авах захиалга өгөх |

| Мөнгө байршуулах заавар | |
|---|---|
| Дансны нэр | Хөрөнгө оруулагчийн нэр |
| Дансны дугаар | ҮЦТХТ-ийн 12 оронтой дансны дугаар |
| Банкны нэр | ҮЦТХТ |
| Гүйлгээний утга | Нэр, Регистр, Бэрс Эй Би Эс Актив ХБҮЦ |

## 6.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

### Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаасны эзэмшигч нь дараах эрхтэй байна.

- Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах
- Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах
- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах
- Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах

УЛААНБААТАР ХОТ БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК АТА8339 6862349 9022060933



MANDAL CAPITAL MARKETS ЗС

СЗХ
2022 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-08-15

## 6.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

ТЗК нь хөрөнгийг өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам зааврыг бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй.

- Үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүний орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;
- Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн " Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам"-д заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

## 6.5 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй.

Мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны "Үнэт цаас гарагчийн мэдээллийн ил тод байдлын журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" болон ТЗК-н ТУЗ-аас баталсан "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээллүүдийг үнэт цаас эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд МХБ-ийн болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Үнэт цаас гаргагчийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь ТЗК нь татан буугдах хүртэл хугацаанд байршина.

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022.08.10
БҮРТГЭВ

2022-08-15

## Улирал тутам хүргүүлэх мэдээлэл

Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
СЗХ болон МХБ-д цахимаар, Хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

- Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт
- Хөрөнгийн багцын нарийвчилсан мэдээлэл, тэдгээрийн байдал
- Хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ,
- Төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон үндсэн зээлийн
- харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт;
- Санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн
- тайлан;
- Хууль тогтоомж, энэхүү журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр
- хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад мэдээлэл
- Жилийн үйл ажиллагааны тайлан

## Хагас жил тутам хүргүүлэх мэдээлэл

СЗХ болон МХБ-д бичгээр Хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

Хагас жилийн тайлан. Үүнд дараах мэдээллүүд багтсан байна:

- Хөрөнгийн багцын үлдэгдэл
- Хугацаандаа болон хугацаа хэтэрч төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ
- Хугацаанааса өмнө төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ
- Ердийн шаардлагад нийцэхгүй болсон буюу хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл

## Жил тутам хүргүүлэх мэдээлэл

СЗХ-д: Дараа оны 02 сарын 20-ны өдрийн дотор СЗХ болон Хөрөнгө оруулагчдад хүргэнэ.
МХБ-д: Дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ

Жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан санхүүгийн тайлан. Үүнд дараах мэдээлэл багтсан байна:

- ТЗК-ийн болон түүний үүсгэн байгуулагчийн аудитын байгууллагаар баталгажсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт
- Үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийн удирдлагын стандарт, шалгуур
- Томоохон үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагч сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл
- ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

Өөрчлөлт гарсан тохиолдолд хүргүүлэх мэдээлэл

| | |
|---|---|
| Холбогдох шийдвэр, өөрчлөлт гарсан, тухайн үйл явдал болсон даруйд буюу ажлын 3 хоногт багтаан Хороо болон МХБ-д бичгээр Хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ. | - Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн мэдээлэл, төлбөрийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэх, хүүний төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд түүний шалтгаан, авах арга хэмжээний тухай<br>- Хөрөнгийн багц, барьцааны зүйлийн нийт үнийн дүнгийн 10 хувь буюу түүнээс дээш хэмжээтэй өөрчлөлт орох<br>- Бүртгэлтэй үнэт цаастай холбоотой аливаа өөрчлөлт (ХБҮЦ-ны нөхцөл, төлбөрийн хуваарь өөрчлөгдөх, гаргасан ХБҮЦ-ийг хугацаанаас нь өмнө буцаан дуудах, нэмэлт үнэт цаас гаргах гэх мэт)-ийн талаарх мэдээлэл<br>- Бүртгэлтэй ХБҮЦ-ны 10.0 хувиас дээш үнийн дүн бүхий буцаан дуудсан, эргүүлэн худалдаж авсан үнэт цаасны мэдээлэл, цаашид 5.0 хувиар өөрчлөгдөх тутамд<br>- ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, дүрэм, журам, хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, холбоо барих хаяг, байршил, утас зэрэгт өөрчлөлт орох<br>- Үнэт цаас эзэмшигчдийн эрхэд өөрчлөлт оруулах, компанийн дүрэм, холбогдох гэрээ, журамд тэдгээрийн эрх ашигт нөлөөлөх нэмэлт өөрчлөлтийг тусгах<br>- Үнэт цаас эзэмшигчдийн хурал зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын мэдэгдэл, хурлаас гарсан шийдвэр<br>- ХБҮЦ-ны харилцаанд оролцогч этгээд солигдох, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, түүнтэй байгуулсан гэрээнд өөрчлөлт орох<br>- Төлбөрийн чадваргүй болох, эсхүл бусад байдлаар шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбоотой мэдээлэл<br>- Эрх бүхий байгууллагаас ХБҮЦ гаргагчид авсан арга хэмжээний тухай<br>- Үнэт цаас эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын шийдвэр, ХБҮЦ гаргагчийн үйл ажиллагаа, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэлд хамаарах бусад мэдээллүүд<br>- Хууль болон журмаар заасан бусад мэдээлэл |

Дээрх мэдээллийг Монгол хэл дээр хүргэх ба шаардлагатай гэж үзвэл гадаад хэл дээр давхар хүргэж болно.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид хүргэхийг хариуцан ажиллах ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хянана.

СЭХ
2022 . 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -08- 15

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Андеррайтер:

MANDAL CAPITAL

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

## 7.1 АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2008/04/02 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011145061 |
| Регистрийн дугаар | 5213487 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамян гүний гудамж, Меру тауэр 602 тоот |
| Утас | +976-7575-9911 |
| Цахим шуудан | info@mandal.capital |

Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани юм. 2008 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж буй Эм Ай Би Жи ҮЦК ХХК-ийн үйл ажиллагаанд 2021 оны 4 дүгээр сард хувьцаа эзэмшил, бүтэц удирдлагын шинэчлэлт хийж, Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн эзэмшлийн компани болсноор нэршлийг Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК болж өөрчилсөн түүхтэй.

Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь СЗХ-с үнэт цаасны үйл ажиллагаа эрхлэх брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Түүнчлэн Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн байгууллага юм.

2021 оны 8 дугаар сард Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын Хөрөнгө Оруулалтын Сангийн нэгж эрхийг нийтэд санал болгох үйл ажиллагаанд "Мандал Капитал Маркетс ҮЦК" ХХК нь идэвхтэй оролцож, нийт татан төвлөрүүлэх санхүүжилтийн 84.0 хувийг буюу 40.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Түүнчлэн 2021 оны 10 дугаар сард Торонтогийн хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн нэмж хувьцаа гаргалтад хамтрагч брокероор оролцож, татан төвлөрүүлэх санхүүжилтийн 28.0 хувь буюу 4.0 тэрбум төгрөгийг дангаар татан төвлөрүүлсэн.

2021 оны 11 дүгээр сард Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь Сэнтрал Экспресс Си Эс Ви ХК-ийн анхдагч зах зээлд нийтэд санал болгох замаар (IPO) татан төвлөрүүлэх санхүүжилтийн 13.0 хувийг буюу 3.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн. Ийнхүү 2021 оны байдлаар Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь нийт 48.1 тэрбум төгрөгийг дотоодын анхдагч зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн туршлагатай хамт олон юм.

2022 оны 06-р сарын байдлаар Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК нь 8.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий биржийн бус зах зээлийн бондын андеррайтераар,

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
он сар өдөр
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-08-15
БҮРТГЭВ-03

Монголын хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр дүнтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох Симпл Ассет хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хамтран андеррайтераар амжилттай ажилласан.

## Андеррайтерийн гэрээний тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.3-д заасны дагуу үнэт цаасыг нийтэд санал болгох ажлын хүрээнд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх Санхүүгийн Зохицуулах Хорооны ТЗ-301/44 тоот тусгай зөвшөөрөлтэй "Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК (Цаашид "Андеррайтер" гэх) нь "Бэрс Эй Би Эс Актив" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх)-тай 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдөр А-22/10 тоот Андеррайтерийн гэрээ байгуулсан. Тус Гэрээний дагуу Андеррайтер нь үнэт цаас гаргах бэлтгэл хангах, зөвлөх үйлчилгээний хүрээнд:

- Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлэлд магадлан шинжилгээ хийсний үндсэн дээр Үнэт цаас гаргагчаас бэлтгэх шаардлагатай баримт бичгүүд, төсөв төлөвлөгөө, мэдээ мэдээллийн талаар зөвлөмжийг тухай бүр Үнэт цаас гаргагчид хүргүүлж үнэт цаас гаргахтай холбоотой бэлтгэл ажлыг хангуулах;
- Нийтэд нээлттэй хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах нарийвчилсан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, тус төлөвлөгөөний дагуу үнэт цаас гаргах үйл ажиллагааг удирдах;
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон бизнесийн үйл ажиллагаанд магадлан шинжилгээ хийж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүтцийг тодорхойлох;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ-ийн бүртгэлийн журмын дагуу Үнэт цаасыг нийтэд санал болгох үйл ажиллагаанд Хорооны шаардлагыг хангасан Түншлэлийн байгууллагатай гэрээ байгуулан, ажиллахад Үнэт цаас гаргагчид зөвлөх;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Биржийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэх журам"-ын дагуу Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах;
- Эрх бүхий этгээдүүдэд үнэт цаас бүртгүүлэх өргөдөл гаргах, бүртгэлийн багц баримт бичгийг бэлтгэх, холбогдох зөвшөөрлийг авахад бүх хүчин чармайлт гаргах.

Үнэт цаасыг нийтэд санал болгох андеррайтерийн үйлчилгээний хүрээнд:

- Үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбогдон гарах маркетинг сурталчилгааны ажил, танилцуулах аянд хамтран ажиллах бөгөөд танилцуулах аян, маркетингийн дэлгэрэнгүй төсөв, төлөвлөгөөг хамтран боловсруулах;
- Үнэт цаасыг нийтэд нээлттэй хүрээнд боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулж, шаардлагатай санхүүжилтыг бүх хүчин чармайлт гаргаж татан төвлөрүүлэх;
- Үнэт цаасны бүртгэл төлбөр тооцоог хөтлөх, гуравдагч талуудтай холбогдох гэрээг боловсруулах;
- Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг нийтэд нээлттэй хүрээнд тохиромжит аргын хүрээнд зохион байгуулахаар тусгагдсан.

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
2022 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ



2022-08-15
БҮРТГЭВ-03

## 7.2 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | **Юнайтед Айр Файнэнс ХХК** |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2005/01/27 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011831586 |
| Регистрийн дугаар | 2870657 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, СТӨ 10 давхар, 1005 тоот |
| Утас | 7012-2346 |
| Цахим шуудан | info@uaf.mn |

Олон нийтэд нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгож байгаа үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдагч болох Юнайтед Айр Файнэнс ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 473 дугаар тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.

Юнайтед Айр Файнэнс ХХК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хувиар банк, банк бус санхүүгийн байгууллага, ОССК болон Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад байгууллагын ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэнэ.

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай байгуулах гэрээний тухай

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг эзэмших, удирдах үндсэн үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хөрөнгийн багцыг удирдах, хяналт тавих;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн хөрөнгийг жагсаалтын дагуу компанийн нэрийн өмнөөс өөрийн программ хангамжаар хүлээн авч, багцын бүртгэлийг баталгаажуулах;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн компанийн данс бүртгэл, санхүүгийн тайлан тооцооноос тусад нь бүртгэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу шилжүүлэн авах хөрөнгө нь ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж ажиллана;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн данс бүртгэлийг хянаж, алдаа, зөрчил илэрсэн бол түүнийг залруулах арга хэмжээг тухай бүр авах, Үйлчилгээ

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
он сар өдөр
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01



2022 -08- 15

үзүүлэгчид шаардлага хүргүүлэх;

- Зээлийн багцтай холбоотой бичиг баримт, мэдээллийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч нараас шаардан авах эрхтэй;
- ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд цугларсан төлбөрөөр ХБҮЦ-ны төлбөр болон ТЗК-ийн бусад төлбөрийн үүргүүдийг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй ТЗК-д мэдэгдэх.

## 7.3 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Онч Аудит ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Аудитын үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2006 он |
| Улсын бүртгэлийн дугаар | 9018001003 |
| Регистрийн дугаар | 2810743 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян-Гүний гудамж, ICC цамхаг, 15 давхар |
| Утас | +976-70120450 |
| Цахим шуудан | info@onch.mn |

Зээлийн шинжилгээ гаргагч нь 2004 онд Онч Аудит ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. Онч Аудит ХХК нь 2012 онд Делоитт (Deloitte) сүлжээнд нэгдсэн бөгөөд өнөөгийн макро эдийн засгийн бизнес болон зах зээлийн сорилтуудын улмаас Делоитт нь Монголын зах зээлээс гарах шийдвэр гаргах хүртэл Делоитт-ийн Монгол дахь салбараар 10 жил үйл ажиллагаа явуулсан. 2022 оны 02-р сарын 01-ээс эхлэн үндэсний бренд Onch & Company-ийн дор аудит, нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг, менежментийн зөвлөх үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ, сургалт болон судалгаа зэрэг үйлчилгээгээр өмнөхтэй ижил дотоод удирдлага, туршлагатай багийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа зах зээл болон үйлчлүүлэгчиддээ амжилттай үргэлжлүүлэн хүргэж байна.

Одоогийн байдлаар Онч Аудит ХХК нь Монголд аудит, татвар, удирдлагын болон бизнесийн зөвлөх үйлчилгээгээрээ салбартаа тэргүүлэгч компаниудын нэг болсон бөгөөд Улаанбаатар дахь оффистоо аудитын Big 4 фирмийн 10 жилийн туршлагатай 50 орчим мэргэжилтэнтэй үйл ажиллагаа явуулж байна.

### Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Аудитын фирм нь Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн талаарх хуульчилсан акт, дүрэм, журам, заавар, стандарт, аргачлалыг удирдлага болгон үйлчлүүлэгчийн тайланг шалгаж баталгаажуулахаар тохиролцсон.

Үйлчлүүлэгчийн тайланг баталгаажуулахдаа:

- Тайлан иж бүрдэл болсон эсэх
- Нягтлан бодох бүртгэлийн бүрэн хөтөлсөн эсэх

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
ATA8339 6862349
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

- Тайланг хөтлөх аргачлалын дагуу гаргасан эсэх
- Хөрөнгийн болон авлага, өглөгийн дансны үлдэгдлийн баталгаа буй эсэх
- Үйл ажиллагааныхаа орлого, зарлага, үр дүнг бүртгэл, тайландаа үнэн зөв бөгөөд бүрэн гүйцэт тусгасан эсэх
- Үйлчлүүлэгчийн хөрөнгө санхүүгийн нөөцийн байршил ба ашиглалтын байдал зэргийг онцлон анхаарна.

Тайлан баталгаажуулахаас гадна үйл ажиллагааны баримтжуулалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалтын талаар мэргэжлийн зөвлөгөө өгөхөөр тохиролцсон.

### Харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гэрээний тухай

Онч Аудит ХХК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК-тай 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гэрээ байгуулсан.

Тус гэрээний дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам" Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400-ийн хүрээнд Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн үнэт цаас гаргахад барьцаалагдах зээлийн багцаас түүвэрлэн шалгаж шалгуур хангаж буй эсэхийг тогтоох, сонгосон аргачлалын дагуу хийхээр тохиролцсон.

Уг ажлыг гүйцэтгэхдээ Батлагдсан зээлийн хөрөнгө тус бүрд тавих шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан зээлийн багцад холбогдох горим хэрэгжүүлэх, тус гэрээний хавсралтад тодорхойлсон шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргахаар тохиролцсон.

## 7.4 ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН |
| Үйл ажиллагааны чиглэл | Хуульзүйн зөвлөгөө өгөх |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2011.07.06 |
| Улсын бүртгэлийн дугаар | |
| Регистрийн дугаар | 5495997 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас | +976-11 330048 |
| Цахим шуудан | info@mdsa.mn |

Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН нь 2011 онд байгуулагдсан. Тус фирмийн хуульчид нь олон улсын эрх зүйг үндэсний хууль тогтоомж, туршлагатай уялдуулан үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад төрөл бүрийн салбарт эрх зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал:

- "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах;
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO, 3 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох төслүүд;
- "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах төсөл;
- "Түмэн шувуут" ХК-ийн IPO;
- "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл дээр хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийг "2021 оны Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байна.

## Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний тухай

Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Бэрс Финанс ББСБ ХХК-тай 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан Д-С1172211 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулсан.

Тус Гэрээний дагуу Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК-аас гаргаж өгсөн мэдээлэл, баримт, материалыг шалгаж, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №2020/06 тоот тогтоолоор батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.5.5 дахь заалтад заасан асуудлын хүрээнд хуулийн дүгнэлт бэлтгэх болон зээлийн хөрөнгийн багцад Үнэт цаас гаргагчтай харилцан тохиролцож баталгаажуулсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд хөрөнгийн багцын бүрдүүлж буй дансдаас сонгогдсон дансдад дүн шинжилгээ хийж, хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг бэлтгэхээр тохиролцсон.

Хуулийн хөндлөнгийн шинжээч, хуулийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу Үнэт цаас гаргагч Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК нь тус Гэрээний дагуу гүйцэтгэх ажилтай холбоотой бүхий л мэдээлэл, баримт бичиг, шийдвэрийг үнэн зөв, бүрэн гүйцэт, шаардлагатай цаг хугацаанд нь тухай бүр гаргаж өгөх, холбогдох тайлбар, нэмэлт мэдээлэл, баримтыг гаргаж өгөх, гэрээгээр тохиролцсон ажлын хөлсийг тохиролцсон хугацаанд бүрэн төлөх, Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч Бэрс Эй Би Эс Актив ТЗК ХХК-ийн гаргаж өгсөн баримт, материал мэдээлэлд үндэслэн хуулийн дүгнэлт гаргахаар тохиролцсон байна.

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-15

Үнэт цаас гаргагч:

Bers ABS active

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

# ХАВСРАЛТ

Андеррайтер:

MANDAL CAPITAL

БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

СЗХ
он 2022 сар 08 10 өдөр
БҮРТГЭВ

## 8.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2022-08-15

МОНГОЛ УЛС

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000258852

2022.05.02
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011839153
/ Хувийн хэргийн дугаар /

6862349
/ Регистрийн дугаар /

Бэрс Эй Би Эс актив ТЗК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр — 01 — 2022.04.28
/ шийдвэрийн нэр / — / дугаар / — / он, сар, өдөр /

66300 — Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
/ Код/ — / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй — 1 — 1,000.00
/ хугацаа / — / гишүүдийн тоо / — / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706 тоот, Утас1: 99119632, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — О.ШИЖИРТУЯА
/албан тушаал/ — /гарын үсэг/

*Гэрчилгээ дахин олгосон 2022 он 06 сар 24 өдөр*

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
6862349
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC

СЗХ
он 2022 сар 08. 18 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Bers ABS active

2022 -08- 15

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Самдан овогтой Отгонбат-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2022.05.02 | Г.Энхтуяа |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2022.06.24 | О.Шижиртуяа |

Энэхүү гэрчилгээг хууран мэхлэж үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000258852

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933



МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC LLC

## 8.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 315/43

2022 оны 06 сарын 22 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 06 сарын 22 өдрийн 355 дугаар тогтоолоор "БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК" ХХК -д Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

СЗХ
он сар өдөр 2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

2022-08-15

*(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)*

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

**ТЗ 315/43 ТООТ**
**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН**
**ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах | 2022.06.22 | №355 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-08-15

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7 хороолол, Ногоон нуур, 101 барилга, 706 тоот. | 99119632 | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2022.06.22 | №355 | 1,000,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01

Bers ABS active

2022-08-15

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Бэрс Финанс ББСБ" ХХК | 6186858 | 1,000,000 | 100% | 2022.06.22 | №355 тогтоол |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

УЛААНБААТАР ХОТ
БЭРС БИ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
ATA8339 6862349
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 оны 08 сарын 10 өдөр
БҮРТГЭВ

2022 -08- 15

Хувьцаа эзэмшигчийн хурлын 2022 оны
06-р сарын 23-ны өдрийн 22/21А/34 тоот
шийдвэрийн хавсралт

**"БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК"**
**ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ**
**КОМПАНИЙН ДҮРЭМ**





БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 ☏ 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

# НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. "Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК /цаашид "Компани" гэхэд "ТЗК" гэх/ нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж энэхүү дүрэм /цаашид "Дүрэм"гэх/-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

1.2. Компанийн оноосон нэр (монголоор)

а) Бүтэн нэр: **"Бэрс Эй Би Эс Актив Тусгай Зориулалтын Компани"** ХХК, товчилсон нэр нь **"Бэрс Эй Би Эс Актив ТЗК" ХХК**

б) Англи нэр буюу товчилсон нэр: **"Bers ABS Active Special Purposed Company" LLC** буюу **"Bers ABS Active SPC" LLC**

1.3. Компанийн оршин байгаа газар:

УБ хот, Сүхбаатар Дүүрэг 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга, 706 тоот

Харилцах утасны дугаар: 99119632

1.4. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл

| Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл | Регистрийн дугаар | Хаяг | Утас |
|---|---|---|---|
| Бэрс Финанс ББСБ ХХК | 6186858 | УБ хот, Сүхбаатар Дүүрэг 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуурын гудамж 101 барилга, 706 тоот | 99119632 |

1.5. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.6. Компани нь ажилтангүй ба өөрийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үйлчилгээг гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлнэ.

1.7. Компанийн одоогийн болон ирээдүйн өр төлбөр нь (татварыг оролцуулан) тоогоор илэрхийлэгдэх ба түүний боломжит эх үүсвэрээр хангагдахуйц боломжтой байна.

## ХОЁР. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан тусгай зориулалтын компани байх бөгөөд эрхлэх цорын ганц үйл ажиллагаа нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу автомашин барьцаалсан зээлийн хөрөнгө худалдан авах, автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт

СЗХ
он 2022 сар 08 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022-08-15

цаас гаргах болон тухайн худалдан авах үнэт цаас гаргахтай холбоотой буюу тэдгээрийн дагуу хийгдэх энэхүү дүрмийн 2.3-т заасан бусад үйл ажиллагаа байна.

2.2. Компанийн зорилго: Компани нь автомашин барьцаалсан зээлүүдийг багцлан худалдан авч, тэдгээрийг өөрийн хөрөнгө болон санхүүгийн тайлан тэнцэлд тусгах бөгөөд худалдан авсан Автомашин барьцаалсан зээлүүдийн төлбөрийг төлөх үүднээс автомашин барьцаалсан зээлээр баталгаажсан үнэт цаас гаргана.

2.3. Компани нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ. Үүнд:

- 2.3.1. Автомашин барьцаалсан зээл худалдаж авах;
- 2.3.2. Автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах;
- 2.3.3. Автомашин барьцаалсан зээл худалдаж авах болон автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор гэрээ байгуулах;
- 2.3.4. Баталгаат үнэт цаас гаргах, түүний төлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээг байгуулах;
- 2.3.5. Гэрээ болон компанийн байгуулсан бусад баримт бичигт заасан компанийн аливаа үүргийг гүйцэтгэх, эрх болон эрхээ хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 2.3.6. Бизнесийн үйл ажиллагааны явцад үүсэх хүүгийн болон бусад санхүүгийн эрсдэлийг удирдах үүднээс дериватив болон валютын ханшийн гэрээ ашиглах;
- 2.3.7. Мөнгөн хөрөнгийг Засгийн газрын үнэт цаас, төв банкны үнэт цаас, дотоодын эсхүл олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас, бусад санхүүгийн хэрэгслийг худалдан авах, банкны хадгаламж, харилцах данс болон банк бус санхүүгийн байгууллагын итгэлцэлд байршуулах;
- 2.3.8. Хууль болон дүрэмд заасан бусад.

2.4. Компани дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- 2.3.9. Дүрэмд заасанаар өөр үйлэмд заасанаар өөр жиллагаа эрхлэхийг хориглоно:л
- 2.3.10. Баталгаат үнэт цаасыг худалдсанаас олсон орлогоос эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр бусдаас зээл авах;
- 2.3.11. Компанийн гаргасан баталгаат үнэт цаас төлөгдөж дуусаагүй байх үед Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрснөөс бусад тохиолдолд өөрийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг төлөх, эсхүл аливаа бусад хэлбэрээр ногдол ашиг хуваарилах;
- 2.3.12. Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах;
- 2.3.13. Хорооны зөвшөөрөлгүйгээр Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

## ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БА ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

3.1. Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй 1,000 (нэг мянга) ширхэг зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцаанаас бүрдэх 1,000,000 (нэг сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болно.



БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

3.2. Компанийн хувьцаа эзэмшигч нь СЗХ-ноос урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөрийн хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах, эсхүл шилжүүлэх эрхгүй.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13-р зүйлийн 13.4-т заасны дагуу Компанийн эрэг өөрийн гаргасан шаардлага, эсхүл түүний өмнө Компанийн хүлээх аливаа үүрэг, хариуцлагатай холбоотойгоор ямар нэгэн хууль зүйн маргаан үүсгэх, хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх, Компанид хариуцлага хүлээлгэхээр санал гаргах буюу санал өгох, эсхүл Дүрмийн 8.2-р заалтад заснаас бусад тохиолдолд Компанийг татан буулгахаар хүсэлт гаргаж үл болно.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

4.1. ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид "ХЭХ" гэх/ байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна. Компанийн ХЭХ-ын бүрэн эрхийг Хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлнэ.

4.2. Компанийн ХЭХ-ийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ шийдвэр гарснаас хойш 10-аас доошгүй хоногийн дараа хуралдуулна.

4.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал -ын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.

4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтална.

4.4.1. ТЗК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

4.4.2. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журамд заасан шаардлагыг хангасан байна.

4.4.3. ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүний чөлөөлсөн, эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр нөхөн сонгоно.

4.4.4. ТЗК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.4.1. Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах;
4.4.4.2. ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах;
4.4.4.3. Эрх бүхий байгууллагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн Компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх,

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ 2022.08.10
№ 01



2022-08-15
ББ-ТЗВ-03

4.4.4.4. Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

4.4.4.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих.

4.4.4.6. Энэхүү Дүрэмд заасан Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах.

4.4.4.7. Компанийн нэр дээр банкны данс нээлгэх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах.

4.4.4.8. Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах.

4.4.4.9. Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр хүлээсэн үүргээ чанд мөрдөж, гүйцэтгэж байгаад хяналт тавьж, хангуулах.

4.4.4.10. Компанийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх.

4.4.4.11. ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон Компанийн дүрэм, Компанийн дотоод дагаж мөрдөж буй журам, зааварт заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

4.4.5. ТЗК-ийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн даргын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн санал, эсхүл Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн санал, шаардлагаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

4.4.6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хурлын ирцийг бүрдүүлэх ба ТУЗ-ийн шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн санал нэгтэй шийдвэрээр батлагдана.

4.4.7. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд тооцогдох бөгөөд тус хуулийн 85-р зүйлд заасан хариуцлага хүлээнэ.





УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
A8339 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

4.4.8. Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн төлөөлж аливаа баримт бичигт ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.

4.4.9. ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Компани Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн Компани татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

## ТАВ. АУДИТ БА ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

5.1. ТЗК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын шаардлага хангасан хөндлөнгийн санхүүгийн аудиторыг томилж гэрээ байгуулна.

5.2. Хөндлөнгийн аудитор нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд жилд 1-ээс доошгүй удаа хөндлөнгийн хяналт шалгалт хийх ба өөрийн үйл ажиллагаандаа Аудитын олон улсын стандарт, Аудитын тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон хэрэгжүүлнэ.

5.3. Хөндлөнгийн аудитор нь аудитын тайлангийн үр дүнг ТЗК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид танилцуулж зохих шийдвэр гаргуулах эрхтэй.

## ЗУРГАА. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

6.1. ТЗК нь санхүүгийн жил тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл байна.

6.2. ТЗК нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг болон бүртгэлийг хадгалж, хувьцаа эзэмшигч болон хуулиар шаардсан эрх бүхий бусад этгээдэд танилцуулахаар санхүүгийн тайланг бэлтгэнэ.

6.3. ТЗК нь санхүүгийн тайлангаа бүртгэх, хөтлөх, тайлагнахдаа Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлана.

6.4. Компанийн бэлтгэсэн нягтлан бодох бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хөрөнгө итгэмжлэн удирдагч хариуцна.

## ДОЛОО.КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

7.1. Автомашин барьцаалсан зээлийг багцлах болон худалдан авсны үндсэн дээр автомашин барьцаалсан зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах, худалдахтай холбоотой аливаа эрсдэл нь Компани болон автомашин барьцаалсан зээлийн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, автомашин барьцаалсан зээлээр баталгаажсан

СЗХ
он 2022 сар 08 өдөр 10
БҮРТГЭВ
№ 01

2022-08-15

баталгаат үнэт цаасны хөрөнгө оруулагч болон тухайн гэрээний тал болсон бусад этгээд бүртэй байгуулсан гэрээ болон бусад баримт бичгээр зохицуулна.

**НАЙМ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ БА ТАТАН БУУГДАХ АЖИЛЛАГАА**

8.1. Энэхүү дүрэм нь компани Санхүүгийн зохицуулах хорооноос Тусгай зориулалтын компани байгуулах зөвшөөрөл олгож, дүрмийн шинэчилсэн найруулгыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.2. ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана.

8.2.1. Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;

8.2.2. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан;

8.2.3. баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан;

8.2.4. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

8.3. ТЗК-ийг татан буулгах асуудлыг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хуулийн 22-р зүйлд заасныар зохицуулна.

"БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК" ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
"БЭРС ФИНАНС ББСБ" ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

.......................................

БААТАРЫН БОЛОР-ЭРДЭНЭ





УЛААНБААТАР ХОТ
БЭРС
ЭЙ БИ ЭС
АКТИВ
ТЗК ХХК

СЗХ
2022 сар 08 10 өдөр
БҮРТГЭВ

**Bers ABS**
**active**

2022-08-15
БҮРТГЭВ-03

## 8.4 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дугаар тушаалаар батлав.

**МОНГОЛ УЛС**
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**
000206010

2017.05.18
*/ Бүртгэсэн он,сар,өдөр /*

9015005096
*/ Хувийн хэргийн дугаар /*

6186858
*/ Регистрийн дугаар /*

Бэрс финанс ББСБ — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
*/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /*

Дүрэм
*/ Үүсгэн байгуулах баримт бичиг /*

| Шийдвэр | 01 | 2017.05.17 |
|---|---|---|
| */ шийдвэрийн нэр /* | */ дугаар /* | */ он, сар, өдөр /* |

| */ Код/* | */ Үйл ажиллагааны чиглэл /* |
|---|---|
| 6492 | Зээлийн үйл ажиллагаа эрхлэх |
| 6619 | Факторингийн үйлчилгээ |

| Хугацаагүй | 1 | 6,090,000.00 |
|---|---|---|
| */ хугацаа /* | */ гишүүдийн тоо /* | */ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /* |

Улаанбаатар, Сүхбаатар, 11-р хороо, 7 хороолол, ногоон нуур, 101 барилга, 706тоот, Утас1: 99119632, Утас2: , Факс:
*/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/*

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
*/ Бүртгэсэн байгууллагын нэр /*

*Гэрчилгээ дахин олгосон 2020 он 05 сар 14 өдөр*

УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 ☎ 6862349
9022060933

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

Bers ABS active

СЗХ 2022 он 08 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

2022-08-15

Мэдээ мэдээлэл - Veritech ERP

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Самдан овогтой Отгонбат-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2017.05.18 | С.Мөнхсанчир |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2020.05.14 | С.Мөнхсанчир |
| 3 | 64300 Итгэмцлийн үйлчилгээ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2020.06.22 | Э.Эрдэнэбалэз |
| 4 | Эмсийн эмчлэгч 1 ирээн бүртгэв. | 2020.10.22 | М.Мөнгөлжин |
| 5 | Баян-Өлгий, Өлгий, 11-р баг, Бүркит, 4/20 айл, 108-байр, 105 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2020.12.18 | С.Арман |
| 6 | Улаанбаатар, Сонгинохайрхан, 32-р хороо, Олон улсын худалдаа Ложистикийн төв, Автоком худалдааны төв, А блок 209 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2021.03.31 | Б.Алтанцэцэг |
| 10 | Дашзэвэг овогтой Нэмэхбаяр-г Эрхлэгч-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв | 2021.08.06 | Н.Энхцэцэг |
| 11 | Өмнөговь, Даланзадгад, 2-р баг, Хан-Уул, ёл 62, 9 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2022.01.14 | М.Оюунгэрэл |
| 12 | 64190 Төлбөрийн баталгаа гаргах /2022.02.23-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2022.03.01 | Н.Зулзаяа |

Энэхүү гэрчилгээг хууран мэхлэх зорилгоор үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022.08.10
БҮРТГЭВ
№ 01

2022-08-15

Зээл төлөгдөж дуусах огноо 2023 оны 04 дүгээр сараас хойш байх шалгуурын хүрээнд График 1-д заасан байдлаар 2023 оны 04 дүгээр сараас хойш зээл эргэн төлөгдөх хугацаатай 54 зээлийг сонгосон. *График 1. 2023 оны 04 дүгээр сараас хойш төлөгдөж дуусах зээлийн дансдын харьцаа*




Зээл олгосон үнийн дүнгийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш байх шалгуурын хүрээнд дараах 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 54 зээлийн дансдыг сонгосон. *График 2. Зээл олгосон үнийн дүнгийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш байх зээлийн дансдын тоо*




Зээлийн төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс их байх шалгуурын хүрээнд 20,000,000 (хорин сая) төгрөгөөс их зээлийн үлдэгдэл бүхий 54 зээлийн дансдыг сонгосон. *График 3. Зээлийн үлдэгдлийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс дээш байх зээлийн дансдын тоо*






УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

Фидуцийн хөрөнгийн үнэлгээ 34,000,000 (гучин дөрөв сая) төгрөгөөс их байх шалгуурын хүрээнд 34,000,000 (гучин дөрөв сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий үнэлгээтэй фидуцийн хөрөнгө бүхий 54 зээлийг сонгосон. *График 4. Фидуцийн хөрөнгө болох автомашины үнэлгээ 34,000,000 (гучин дөрөв сая) төгрөгөөс дээш зээлийн дансны тоо*




### Дүн шинжилгээ хийсэн аргачлал

Хөндлөнгийн дүн шинжилгээ хийхдээ сонгогдсон зээлийн дансны зээлийн хувийн хэрэг (зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хувийн мэдээлэл, орлого нотолсон баримт зэрэг), түүнд агуулагдсан Бэрс Финанс ББСБ-ын дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримт, үйл баримтыг Бэрс ЭБС Актив-тай урьдчилан тохиролцож, баталгаажуулан бэлтгэсэн шалгуур болон МДСХ-ийн зүгээс боловсруулсан шалгуурын дагуу шалгах, үнэлэх замаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн дансдыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бэрс Финанс ББСБ-аас цахим болон цаасан хэлбэрээр авч шалгах буюу өөрийн байранд биечлэн гүйцэтгэсэн.

### Дүн шинжилгээ хийсэн арга зүй

Дүн шинжилгээ хийхдээ Бэрс ЭБС Активын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 22/21а/32 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтаар баталсан "Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам", "Хэлцлийн хүрээнд худалдан авах хөрөнгийн багцад тавигдах хуулийн шалгуур үзүүлэлт"-д тодорхойлсон ХБҮЦ гаргах хэлцлийн хүрээнд хөрөнгийн багцад тавигдсан хуулийн 6 шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрээнд МДСХ-ийн зүгээс боловсруулсан 72 шалгуур асуултын дагуу хууль тогтоомжийн хүрээнд Бэрс Финанс ББСБ-ын гаргаж өгсөн зээлийн дансны хувийн хэрэг, түүнд агуулагдсан материал болон Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг, хууль тогтоомжид тулгуурлан бэлтгэлээ. Бэрс ЭБС Активын зүгээс өгсөн хөндлөнгийн шинжилгээнд зөрчилд тооцохгүй буюу "Автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (ХБҮЦ) гарган нийтэд санал болгоход анхаарах "ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт"-ыг энэхүү Тайлангийн Хавсралт 2-т тусгав.

Дүн шинжилгээ хийх явцад нэмэлт тодруулга, тайлбар, нотлох баримт шаардлагатай асуудлаар Бэрс Финанс ББСБ-д тухай бүр цахим шуудан илгээж хариу тайлбар, нотлох баримтуудыг хүлээн авсан болно.

МДСХ нь сонгогдсон зээлийн дансыг шалгуур үзүүлэлтийн асуултын дагуу шалгаж шалгуур үзүүлэлтийн асуултанд хариулах замаар үнэлсэн. Зээлийн данс нь шалгуур үзүүлэлтийг хангасан түвшингээр нь улаан, шар, ногоон өнгөөр ялгаж тодруулсан. Үүнд:

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн дансыг улаан өнгөөр тэмдэглэсэн.

☆ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатайг шар өнгөөр тэмдэглэсэн.

★ - Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь зээлийн дансны шалгуур үзүүлэлт, хуулийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр зээлийн дансыг ногоон өнгөөр тэмдэглэсэн.

Нэгдсэн дүгнэлтийг гаргахдаа зээлийн дансыг бүрдүүлж буй зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь улаан, шар өнгөөр тэмдэглэгдсэн нөхцөлд зээлийн данс нь эрсдэлтэй бүлэгт орохоор тооцож үнэлсэн.

Зарим зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийн талаар анхаарах асуудлыг Бэрс ЭБС Актив-д мэдээлэл өгөх зорилгоор энэхүү Тайлангийн санамж/зөвлөмж хэсэгт дурдсан болно.

## Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан баримт бичиг

Энэхүү Тайланг дор дурдсан материалуудын үндсэн дээр гаргасан болно. Үүнд:

1. Бидэнд нээлттэй, ил болгон өгөгдсөн анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргаж өгсөн материалууд;
2. Хууль тогтоомж:

*Хууль*

2.1. Иргэний хууль (2002);
2.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002);
2.3. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021);
2.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010);
2.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013);
2.6. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль (2010);
2.7. Зээлийн мэдээллийн тухай хууль (2011);
2.8. Нотариатын тухай хууль (2011);
2.9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2017);
2.10. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009);
2.11. Автотээврийн тухай хууль (1999);
2.12. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015);
2.13. Зөрчлийн тухай хууль (2017);
2.14. Даатгалын тухай хууль (2004);
2.15. Жолоочийн даатгалын тухай хууль (2011).

*Журам*

2.16. СЗХ-ноос баталсан Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам (2022);
2.17. СЗХ-ноос баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам (2011);
2.18. МХБ-ээс баталсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам (2020);
2.19. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаалаар баталсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам (2011);
2.20. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам (2020);
2.21. Засгийн газраас баталсан Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм (2018);
2.22. Бусад холбогдох хууль тогтоомж.

## Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Тайланг боловсруулахдаа бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх тэмдэгтийн хураамжийн төлбөр нь төлөгдсөн гэсэн тэмдэглэгээ болон бусад аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн бөгөөд, одоо хүчин төгөлдөр байгаа, цаашид хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд тэрхүү

баримт бичгийн талуудын тухайн баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэг нь бүх холбогдох хуулийн хүрээнд бүрэн хүчин төгөлдөр хэрэгжинэ;

3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, цаашид ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр хүчин төгөлдөр хэрэгжинэ;
4. Зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид эх хувиар хадгалагдаж байгаа;
5. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
6. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан болно;
7. Тухайн баримт бичгүүд дээр төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас авах шаардлагатай зөвшөөрөл, батламжийг авсан, зохих шийдвэр гарсан, тэдгээр баримт бичгийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах аливаа бусад хэлцэл хийгдсэн, бусад баримт бичгүүд үйлдэгдсэн;
8. Төрийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт, лавлагаа, Төрийн үйлчилгээний цахим (ТҮЦ) машины албан ёсны хэвлэмэл хуудас бүхий лавлагаа нь зээлийн хувийн хэрэгт байх тохиолдолд тус лавлагааг авахад шаардлагатай аливаа хураамж, төлборийг төлсөн;
9. Бэрс Финанс ББСБ, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
10. Тээврийн хэрэгслийн даатгал болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын төлбөр бүрэн төлөгдсөн;
11. Зээлдэгчид зээл олгохын өмнө Бэрс Финанс ББСБ нь фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, гаалийн мэдүүлэг, татвар төлсөн эсэхийг авч шалгадаг.
12. МДСХ нь энэхүү Дүн шинжилгээний явцад холбогдох ажилтнуудаас тодруулга мэдээллийг газар дээр нь авч ажилласнаас гадна нэмэлт мэдээлэл тодруулга шаардлагатай дансдын талаар цахим шуудан илгээж холбогдох нотлох баримт, тодруулгыг авч ажилласан.
13. Хөндлөнгийн санхүүгийн шинжээч нь өр орлогын харьцаа, орлого нотлох баримтыг шалгадаг.
14. Бэрс Финанс ББСБ нь тээврийн хэрэгсэл (автомашин)-ийн урьдчилгаа төлбөр төлсөн эсэхийг шалгадаг.

Бид дараах нөхцөлөөр тайланг боловсруулсан болно. Үүнд:

1. Энэхүү тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд энэхүү судалгаа шинжилгээ нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд автомашины фидуци бүхий зээлтэй холбоотой дурдагдсан аливаа тоон мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Энэхүү тайланд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү тайлангийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Энэхүү Тайланд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү судалгаа шинжилгээтэй холбоотой бид гаргахгүй болно;



БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
6862349
2060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

5. Бидний судалгаа шинжилгээ нь энэхүү Тайлан гарах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно;
6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргуулан үзсэн зээлийн хувийн хэргүүдэд хийсэн судалгаа нь зээлийн хувийн хэргүүдийн ерөнхий төлөөлөл, эсхүл тэрхүү хувийн хэргүүдийн багцын төлөөлөл, эсхүл аливаа ерөнхий дүгнэлт, санал гаргахад хангалттай статистик мэдээлэл болж тайлбарлагдахгүй, тооцогдохгүй болно.
7. Түүврийн аргаар сонгосон зээлийн дансдаас бусад зээлийн данстай холбоотой дүгнэлт гаргаагүй болно;
8. Фидуцийн зүйл болох автомашины бүрэн бүтэн байдал, элэгдэл, чанарын талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн болон түүний эзэмшлийн талаарх нөхцөл байдлыг тогтоохгүй болно.

Энэхүү Тайланг гаргахдаа фидуцийн гэрээнүүд хуульд заасны дагуу зохих ёсоор, үнэн зөв, бүрэн гүйцэд байдлаар байгуулагдаж, эрх бүхий этгээдээр батлуулан, автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага (Авто тээврийн үндэсний төв)-д бүртгүүлсэн гэж үзсэн болно.

### Материал хадгалах хугацаа

МДСХ нь хуулийн тайлан гаргахад ашигласан болон судалгаа шинжилгээнд хамруулсан зээлийн данс бүрийг шалгаж баримтжуулсан баримт бичиг, эцсийн тайланг Үнэт цаас гаргагчид хүлээлгэж өгснөөс хойш 2 (хоёр) жилийн хугацаанд хадгална.

## ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ ДҮГНЭЛТ

### Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх.

МДСХ нь нэгдүгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон нийт 54 зээлийн дансны зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр эсэх, фидуцийн гэрээний дагуу тээврийн хэрэгсэл буюу автомашин нь улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэх, мөнгөн төлбөрийн үүрэг болон фидуцийн зүйлийг шаардах эрх нь аливаа үүргээс ангид байсан эсэхийг нягталж шалгалаа.

Бэрс Финанс ББСБ-ын үндсэн зээлдэгч, эсхүл хамтран зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, фидуцийн гэрээг талуудын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан эх хувийг, фидуцийн зүйлийн өмчлөгчөөр бүртгэгдсэн авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар хувийг шалгасан. Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашиныг Зээлдүүлэгч өмчилж буй боловч автомашиныг Зээлдэгч эзэмшиж ашигладаг байна. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.1, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8[1]-д заасны дагуу механикжсан тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээтэй байх ба тээврийн хэрэгслийн гэрчилгээ холбогдох бусад баримт бичгийн хамт тээврийн хэрэгслийг жолоодохоор заажээ. Ийнхүү тус хууль тогтоомжийн дагуу Бэрс Финанс ББСБ нь тээврийн хэрэгслийн гэрчилгээг хуулбар хувь нь хадгалах ба хуулийн хөндлөнгийн шинжээчид үзүүлэх боломжгүй байна.

Бид зээлийн хувийн хэргийн материалыг шалгахад сонгогдсон 54 зээлийн дансдын тээврийн хэрэгсэл (автомашин)-ийн гэрчилгээний хуулбарт Бэрс Финанс ББСБ өмчлөгчөөр бүртгэгдсэн байна.

Авто тээврийн тухай хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д тус тус заасны дагуу бүх тээврийн хэрэгслийн гэрчилгээг авто тээврийн асуудал эрхэлсэн бүртгэлийн байгууллагаас олгосон байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ (хуулбар хувь)-г

[1] *Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8. Замын хөдөлгөөний дүрэмд заасан баримт бичиггүй тээврийн хэрэгсэл жолоодсон [illegible]*



БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 08 10
БҮРТГЭВ
№ 01



2022 -08- 15

бүртгэлийн байгууллага бүртгэж, баталгаажуулсан эсэхийг бүртгэгчийн тамга, тэмдэглэгээгээр гэрчилснээс үзвэл фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь зохих ёсоор бүртгэгдэж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь Бэрс Финанс ББСБ-д олгогдсон байна. Түүнчлэн, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-т "Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлт буюу гэрчилгээгээр баталгаажсан байна", 21.4-д "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлага хангасныг гэрчлэх шинжлэх ухааны холбогдох байгууллага, эсхүл техникийн хяналтын үзлэг, оношилгооны дүгнэлтгүйгээр тухайн тээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно". Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмын 10 дугаар зүйлийн 1.2-т зааснаар "техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй бол авто тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзана" гэж заасны дагуу фидуцийн зүйл болох тээврийн хэрэгсэл нь хуульд заасан техник хяналтын үзлэгт хамрагдсан гэж үзэж байна. Мөн журмын 10 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.9-т тус тус зааснаар "авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, хуулийн дагуу оногдуулсан торгуулийг төлж барагдуулаагүй, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй бол тээврийн хэрэгслийг бүртгэхээс татгалзах"-аар зохицуулсан тул тээврийн хэрэгсэлтэй холбоотой татвар, торгууль байхгүй, эсхүл бүрэн төлөгдсөн байж тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн гэж үзэв.

Иймд дүн шинжилгээ хийх явцад зээлийн дансны хувийн хэрэгт авагдсан материал, Бэрс Финанс ББСБ-ын өгсөн нэмэлт мэдээллийн дагуу зээлийн дансыг бусад гуравдагч этгээдэд худалдах, уг зээлийн мөнгөн хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөрийн шаардах эрх, фидуцийн зүйлийн шаардлагыг бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэлд тавьсан нөхцөл байдал илрээгүй учир сонгогдсон зээлийн дансдын фидуцийн зүйл болох автомашин нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх шалгуур хангагдаж байна гэж дүгнэлээ.

МДСХ нь санамсаргүй түүврээр сонгогдсон 54 зээлийн дансанд хамаарах автомашины зээл нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу Бэрс Финанс ББСБ-ын бүрэн өмчлөлд байгаа бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байна гэж үзлээ.

Шалгуур үзүүлэлт 2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа (фидуцийн) хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Бэрс Финанс ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг шаардлагатай тохиолдолд фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгслээс гаргуулан төлүүлэх нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Нийт дүн шинжилгээнд хамрагдсан зээлийн дансдын хувьд БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6[2]-д заасан зээлийн гэрээнд "зээлийн дансны дугаар", "зээлийг бүхэлд нь болон хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл" тусгагдаагүй байсан байсан бөгөөд "ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлуудын жагсаалт"-ын 23-д зарим нөхцөл тусгагдаагүй байж болох тухай заасны дагуу бид эрсдэлтэй зээлийн дансдын тоонд оруулаагүй болно. МДСХ нь зээлийн гэрээнд тусгасан байх ёстой нөхцөлүүдийг бүрэн тусгах зөвлөмжийг энэхүү Тайлангийн зөвлөмж хэсэгт тусгасныг анхаарах шаардлагатай байна.

Энэхүү дурдсан 2 нөхцөлөөс бусдаар зээлийн гэрээнд тусгасан байх бусад нөхцөлийг зээлийн гэрээндээ тусгасан, зээлийн гэрээ, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд зээлдүүлэгч болон хамтран зээлдэгч гарын үсэг зурсан нь Иргэний хуулийн 42.2, 451.2 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн

[2] "20. 2 Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна. 20.2.3 зээлийн дансны дугаар; 20.2.6 зээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл."



УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (цаашид "БЭБХЭМХМХШЗҮАтХ" гэх)-ийн 19.3 болон 20 дугаар зүйлд тус тус тодорхойлсон шаардлагыг хангасан байна (Тайлангийн зөвлөмж хэсгийг харна уу).

Бэрс Финанс ББСБ-аас зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд, эсхүл гэрээгээр тохиролцсон, тусгайлан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр гуравдагч этгээдийн дансанд шилжүүлсэн нь БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19.5-д "Зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсхүл зээлдэгч зээлийн данснаас зээлээ ашигласныг зээл олгосонд тооцно" гэж заасантай нийцэж буй тул зээл олголт нь хуулийн хүчин төгөлдөр болно.

Түүнчлэн зээлийн гэрээ нь Бэрс Финанс ББСБ-аас зээлдэгчид санал болгож байгаа, хуулийн заалтыг тодотгосон журам тогтоосон, байнга хэрэглэгдэх шинжтэй, урьдчилан тогтоосон нөхцөл болохын хувьд Иргэний хуулийн 200 дугаар зүйлд заасан стандарт гэрээний нөхцөл болно. Гэрээний зохицуулалтаас харвал, зээлийн гэрээ нь Иргэний хуулийн 202 дугаар зүйлд заасан гэрээний стандарт нөхцөлийг хүчин төгөлдөр бусад тооцох зохицуулалт агуулаагүй байна.

Бэрс Финанс ББСБ-ын 2101130101021436 тоот зээлийн дансны зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хамтран зээлдэгч нь гарын үсэг зураагүй бөгөөд үндсэн зээлийн гэрээнд зээлдэгч, хамтран зээлдэгч нар гарын үсэг зурсан байдаг. Үндсэн зээлийн гэрээнд хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болохыг дурдсан байх тул энэ нь зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй, үүнээс үүдэн гарах хууль зүйн эрсдэл бага гэж үзлээ.

Түүнчлэн нийт зээлийн дансдын хувьд зээлийн гэрээний 1.2[5].-т зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож фидуцийн хөрөнгө болох тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлэх тухай дурдсан байх тул зээлийг фидуцийн хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байна гэж үзлээ.

Иймд, сонгогдсон нийт 54 зээлийн дансны тээврийн хэрэгсэл/автомашин худалдан авах, эсхүл эргэлтийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө өмчлөх зэрэг зориулалтаар зээл олгох хэлцэл нь зээлдэгч (үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн байх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

Шалгуур үзүүлэлт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь түүврийн аргаар сонгосон 54 зээлийн дансдын хувьд зээлийн гэрээ, фидуцийн гэрээнд тусгагдсан үүрэг хугацаанаас өмнө дуусгавар болох, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах нөхцөлүүд болон үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай хүсэл зориг илэрхийлсэн эсэх талаар шалгаж үзлээ.

Иргэний хуулийн 283.3-д заасанаар "талууд урьдчилан тохирсон буюу зээлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд" зээлдэгч зээлээ урьдчилан төлөх боломжтой тухай зохицуулсан байдаг. Хэдийгээр энэ талаар зээлийн гэрээнд зохицуулалт тусгагдаагүй ч зээлдэгч нь хуульд заасны дагуу зээлийн гэрээний төлбөрийг урьдчилан төлөх эрхтэй.

Тайлан гаргах өдрийн байдлаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр сонгогдсон 54 зээлийн дансдын зээл олгох хэлцэл нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамааруулан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх тул энэхүү шалгуур үзүүлэлтийг хангаж байна.

---

[5] *Гэрээний үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор барьцаа хэрэгсэл болох тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг Зээлдүүлэгч зээлдүүлэгчийн төлөөлөгч рүү шилжүүлэх.*

СЗХ
2022 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022 -08- 15

Шалгуур үзүүлэлт 4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд МДСХ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуци болон зээлийн мөнгөн хөрөнгийг эргүүлэн шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэхэд хууль болон гэрээгээр хориглосон, хязгаарласан нөхцөл байгаа эсэх, фидуцийн зүйл хамтран өмчлөгчтэй тохиолдолд хамтран өмчлөгчийн зөвшөөрөл байгаа эсэх, хамтран өмчлөгч фидуцийн гэрээнд гарын үсэг зурсан эсэх зэрэг асуудлыг шалган үзлээ.

Бэрс Финанс ББСБ нь зээлдүүлэгч зээлийн гэрээний шаардах эрхийг үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийн хамт бусдад шилжүүлэхийг хориглоогүй, аливаа байдлаар хязгаарлаагүй байх талаар зээлийн гэрээнд тусгаагүй байна. Гэвч Иргэний хуулийн 123.3-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрхийг шилжүүлэхийг хязгаарласан нөхцөл байхгүй тохиолдолд шаардах эрх эзэмшигч нь уг эрхээ Иргэний хуулийн 123.2-т заасны дагуу үүргийн мөн чанарт харшлаагүй нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн зөвшөөрлийг авахгүйгээр бусдад шилжүүлэх эрхийг олгосон байна. Зээлийн гэрээнд энэхүү эрхийг хязгаарласан аливаа зохицуулалт ороогүй болно.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшдэг болохыг дурдахын зэрэгцээ дүн шинжилгээнд хамрагдсан 54 зээлийн данснаас 54 зээлийн дансны хувьд автомашины зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ, эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, бусдад шилжихийг хориглогдоогүй, эсхүл хязгаарлаагүй байх шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэв. Түүнчлэн фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашины цорын ганц өмчлөгч нь Зээлдүүлэгч (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч) байх ба фидуцийн зүйлтэй холбоотой хамтран өмчлөгчийн эрх байхгүй болохыг бид шалгасан болно. Иймд, зээл төлүүлэх зорилгоор автомашиныг барьцаалуулах, худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрхийг фидуцийн гэрээний дагуу түүнийг өмчилж буй Анхны үүрэг гүйцэтгүүлэгч эдэлнэ. Харин эзэмших, ашиглах эрхийг өөр этгээд хэрэгжүүлж байгаа нь ажиллагааны шуурхай байдалд нөлөөлж болох талтайг дурдах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлт 5. Зээлтэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх.

Уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд Бэрс Финанс ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан фидуцийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх, хуульд зааснаар, эсхүл итгэмжлэлээр төлөөлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, фидуцийн эрх нь үүргийн гүйцэтгэлээр хангах аргаар баталгаажсан бусад шаардлагаас давуу, тэргүүн ээлжинд шаардлага хангуулах боломжтой эсэх, зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон эсэх зэрэг асуудлыг шалгаж үзлээ.

Тайлангийн шалгуур 2-т дурдсаны дагуу түүврийн аргаар сонгосон зээлүүдийн зээлийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр байна. Зээлдэгч зохих ёсоор үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн гэрээ болон фидуцийн гэрээгээр зохицуулсан байна. Иймд талууд фидуцийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зөвшөөрсөн байна.

Иргэний хуулийн 235.5-д "хуульд өөрөөр заагаагүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр хийнэ" гэж заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгэгч нь фидуцийн эрхийг баталгаажуулсан гэрээг зээлдэгчтэй бичгээр байгуулсан нь Фидуцийн гэрээний хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангасан байна. Мөн сонгогдсон 54 зээлийн дансдад итгэмжлэлээр төлөөлүүлж гэрээг байгуулсан тохиолдол гараагүй тул хуульд заасан төлөөлөх, төлөөлүүлэх харилцаа үүсээгүй болно.

Фидуцийн гэрээний 1.9-т "Энэхүү гэрээний 1.7-д заасан мэдэгдлийг авснаас хойш Зээлдэгч нь зээл төлөх ямар нэг үйлдэл хийгээгүй бол мэдэгдэх хуудас хүргүүлсэн өдрөөс хойш 15 хоногийн



УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК
АТА8339 6862349
9022060933



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
он сар өдөр
2022 09 1
БҮРТГЭВ
№ 01



2022 09 1
БҮР

.......... хөрөнгийг бусдад худалдах, болон бусад хэлбэрээр борлуулж хохирлоо барагдуулна" гэж зохицуулснаас үзвэл, фидуцийн эрх нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн зээлийг фидуцийн зүйл болох автомашиныг худалдан борлуулж төлүүлэх боломжтой байх шалгуурыг хангаж байна (Тайлангийн Зөвлөмж хэсгийг харна уу).

Мөн Иргэний хуулийн 235.1, Фидуцийн гэрээний 1.4-т "Барьцаалагчийн зөвшөөрөлгүй, зээл хаагдаагүй байхад Барьцаалуулагч нь барьцаа болох хөдлөх хөрөнгийн эзэмшил ашиглалтыг, өмчлөх эрхийг хууль бусаар гуравдагч этгээдэд шилжүүлэх, бусдад дамжуулах худалдах, барьцаалахыг хориглоно" гэж зохицуулснаас үзвэл Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь фидуцийн өмчлөгч бөгөөд зээлдэгч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр фидуцийн хөрөнгийг бусад үүргийн гүйцэтгэл хангуулахаар барьцаалах зэргээр захиран зарцуулах боломжгүй тул зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг давуу буюу тэргүүн ээлжинд фидуцийн эрхээр хангуулахаар талууд тохиролцсон гэж үзнэ.

Иймд, Бэрс Финанс ББСБ-ын фидуцийн гэрээ нь хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн, зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг фидуцийн эрхээр гаргуулах боломжтой байна.

Шалгуур үзүүлэлт 6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болохоос Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгогдсон зээлийг ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу олгосон эсэх, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байгаа эсэхийг шалгалаа.

Энэхүү хүрээнд сонгогдсон зээлийн дансдыг шалгах явцад Бэрс Финанс ББСБ-ын Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн шимтгэлийг зарим тохиолдолд авах, зарим тохиолдолд аваагүй зэрэг ялгаатай байдал илэрсэн болно. Энэхүү хүрээнд "Ковид"-ийн хуулийн дагуу Зээлийн үйл ажиллагааны журамд заасан шимтгэлийн хувийг Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 03-р сарын 10-ны өдрийн 20/17а/22 тоот тушаалаар тус өдрөөс эхлэн зээлийн шимтгэлийг 0% болгосон ба 2021 оны 03-р сарын 09-ний өдрийн 21/17а/24 тоот тушаалаар орон нутаг болон алслагдмал газарт байрлах салбараас олгосон зээл, 2022 оны 04-р сарын 22-ны өдрийн 22/17а/22 тоот тушаалаар Улаанбаатар хот дах салбараас олгосон зээлийн шимтгэлийг сэргээсэн байна. Хэдийгээр Зээлийн үйл ажиллагааны журмын шимтгэлтэй холбоотой нөхцөлд өөрчлөлт оруулаагүй боловч зээлийн үйл ажиллагааны журам батлах эрх бүхий субъект нь өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан байх тул дурдсан тушаалыг үндэслэл болгон шалгасан болно.

Түүнчлэн Зээлийн үйл ажиллагааны журамд заасан зээлийн хорооны шийдвэр гарах нөхцөл, журам буюу зээлийн хорооны шийдвэрээр шийдвэрлэх зээлийн үнийн дүнгийн хэмжээг Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 07-р сарын 21-ний өдрийн 21/17а/64 тоот тушаал, 2022 оны 03-р сарын 22-ны өдрийн 22/17а/24 тоот тушаал, Гүйцэтгэх захирлын 2022 оны 02-р сарын 08-ны өдрийн 22/17а/09 тоот тушаалаар өөрчлөлт оруулан шийдвэрлэснийг мөн дээр дурдсантай адил удирдлага болгон зээлийн дансдыг шалгасан болно.

Бэрс Финанс ББСБ-ын сонгогдсон 54 зээл нь зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор дотоодод дагаж мөрддөг журмын дагуу олгогдсон, фидуцийн хөрөнгө нь фидуцийн хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой дотоодод дагаж мөрддөг журмын дагуу тодорхойлогдож, шаардлага хангасан байна.



УЛААНБААТАР ХОТ
БЭРС
ЭЙ БИ ЭС
АКТИВ
ТЗК ХХК



MANDAL CAPITAL
MARKETS SC
LLC

СЭХ
2022 он 08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-08-15

Шалгуур 1-т дурдсаны дагуу зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь эх хувиар, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь хуулбараар хувийн хэрэгт хадгалагдаж байв. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд буй фидуцийн зүйл болох автомашиныг зээлдэгч (эсхүл түүний итгэмжилсэн этгээд) эзэмшиж, ашиглаж байна. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн эзэмшил, хадгалалтад эх хувиар байлгадаггүй нь Автотээврийн тухай хуулийн 17.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21.2-д заасан хууль зүйн үндэслэлтэй, хуулбарыг хувийн хэрэгт хадгалдаг байна. Ийнхүү үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй дээр дурдсан баримт бичгийн нь эх хувь, эсхүл хуулбар хувиар анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалтад хамгаалалтад байна гэж үзлээ.

## Нэгдсэн дүгнэлт

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нийт 54 зээлийн дансны хувьд Дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ нь хүчин төгөлдөр, аливаа эрсдэл үүсээгүй байна.

Энэхүү Тайлангийн Хавсралт 2-т заасан Бэрс ЭБС Активын зээлийн багцын шинжилгээний явцад анхаарах банк бус санхүүгийн байгууллагад ялгаатай шийдвэрлэгдсэн асуудлын жагсаалтад заасны дагуу бид тус зөрүүтэй зохицуулалтыг илрүүлсэн хэдий ч хүлээн зөвшөөрсөн бөгөөд дүн шинжилгээ хийх явцад гарсан алдаа, зөрчлийг тухай бүр засуулсан болно.

1. Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан данслуул.

Энэ ангилалд багтсан нийт данс БЭРС ЭБС АКТИВ-аас тавигдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан (Хавсралт 1. Түүврийн аргаар сонгогдсон зээлийн статус) бөгөөд Зээлийн гэрээ, Фидуцийн гэрээ, Тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр байгаа үтгыг илэрхийлнэ. Энд гарсан алдаа нь эрх зүйн эрсдэл үүсгэхгүй, хууль тогтоомжоор заасан шаардлага зөрчөөгүй зээлийг ойлгоно. Гэвч энд зарим эрсдэл болох тухайн зээл авахад шаардлага хангаж байсан боловч хөндлөнгийн дүн шинжилгээ хийх үед өөрчлөгдсөн нөхцөл байдал орж байгаа болно. Тухайлбал, зээл авах үед үйл ажиллагаа явуулах эрхийн зөвшөөрөл, эсхүл ажил эрхлэлт, тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ нь хүчинтэй байсан боловч энэхүү тайлан гаргах өдрийн байдлаар хугацаа нь дууссан байх магадлалтай зээлийн данс орсон байж болно.

2. Эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай данс.

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь, эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь эрсдэлтэй байж болзошгүй, эрсдэлийн зэргийг дахин үнэлэх шаардлагатай зээлийн данс илрээгүй болно.

3. Хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй данс.

Дүн шинжилгээ хийж тайлан гаргах өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээний аль нэг нь эсхүл түүний гол нөхцөлийг тодорхойлсон заалт нь хүчин төгөлдөр бусад тооцогдож болзошгүй, хуулийн шаардлага хангаагүй зээлийн данс илрээгүй болно.

*График 5 Зээлийн гэрээ, фидуцийн гэрээний хүчин төгөлдөр байдлын үзүүлэлт.*



БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 08 10 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



2022-08-15




Энэхүү тайлан нь түүнийг тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй.

## ГУРАВ. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Фидуцийн гэрээний загварыг хуульд нийцүүлэх шаардлагатай. Үүргийн гүйцэтгэлийн хангах харилцааны зүйл болох хөдлөх хөрөнгө нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилждэг үндсэн шинжийг үгүйсгэж, барьцааны зохицуулалттай хольсон агуулгыг Фидуцийн гэрээний загварт тусгасныг зөвтгөх шаардлагатай.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн дансдын хувийн хэрэгт зээлийн хяналтын тайлан үйлдээгүй байна. Зээл олгосноос хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа зээлийг эргэн шалгадаг байх, даатгалын хугацаа дууссан эсэх зэрэг мэдээллийг шалгах шаардлагатай учраас зээлийн хяналтын тайлан үйлдэн хувийн хэрэгт хавсаргадаг байх шаардлагатай гэж үзлээ.

БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу зээлийн хувийн хэрэгт зээлийн ашиглалт шалгасан баримт бичгийг нэмж бүрдүүлдэг болох шаардлагатай. Энэ талаар тодруулахад "Зээлийн үйл ажиллагааны журмаар харилцагчаас зээлийн ашиглалт шалгана гэж заагаагүй тул материалд хавсаргаагүй" гэх хариу ирүүлсэн нь хууль зүйн хувьд үндэслэлгүй байна. Иймд цаашид хууль тогтоомжид нийцүүлэн Зээлийн үйл ажиллагааны журамд ашиглалт шалгасан баримт бичгийг хувийн хэрэгт хавсаргах зохицуулалт оруулах, үүнийг өөрийн үйл ажиллагаанд мөрдлөг болгохыг зөвлөж байна.

Зөрчлийн тухай хуулийн 5.6-д зааснаар зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, тухайн зөрчил гаргасан үйлдлээс олсон орлогыг хурааж хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулах хариуцлага хүлээхээр байгааг анхаарна уу.

Мөн тээврийн хэрэгслийн даатгалын гэрээг зээлийн гэрээний үнийн дүнгээс бага үнийн дүнгээр байгуулсан тохиолдол зарим зээлийн дансдын хувьд илэрсэн бөгөөд энэ тохиолдолд даатгалаар хамгаалагдаагүй үнийн дүнд хамаарах эрсдэлийг зээлдэгч хариуцахаар баталгаа гаргуулан авах нь цаашид үүсэх эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой байна.

Сонгогдсон зээлийн дансдын заримд нь зээлийн үнийн дүнг "XXX" ХХК буюу тээврийн хэрэгсэл нийлүүлэгчийн дансанд шилжүүлсэн тохиолдол илэрсэн. Хэдийгээр тус компанийн дансанд шилжүүлэхийг талууд гэрээ (тусгайлсан зөвшөөрөл бүхий бичиг)-ээр тохиролцсон боловч зээлийн гэрээ нь бодит хэлцэлд хамаарахын хувьд зээлийн төлбөрийг зээлдэгчийн дансанд шилжүүлж байх нь зүйтэй байна.

Түүнчлэн шалгуур 2-т дурдсанчлан зээлийн гэрээнд БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т заасан "зээлийн дансны дугаар", 20.2.6-д заасан "зээлийг бүхэлд нь буюу



УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022.08.10 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

хэсэгчлэн эргүүлэн төлөх нөхцөл" тусгагдаагүй зөрчил илэрсэн. Ийнхүү илэрсэн зөрчил нь ялгаатай шийдвэрлэсэн асуудлуудын жагсаалтад багтсан хэдий ч цаашдаа БЭБХЭМХМХШЗҮАтХ-д нийцүүлэн тус нөхцөлүүдийг тусгах нь түйтэй байна. Ийнхүү тусгаагүйтэй холбоотойгоор Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1[4]-д заасны дагуу хуульд зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус болох эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн нийт зээлийн дансдын хувьд зээлдэгч, хамтран зээлдэгч нар нь шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг аваагүй байсан. Үүнтэй холбоотойгоор зээлдэгчийн төлбөрийн чадварыг судлахдаа шүүхийн шийдвэрээр өр төлбөртэй эсэх лавлагааг авдаг, энэ талаарх мэдээллийг аливаа хэлбэрээр шалгадаг байх нь зээлийн төлбөр төлөгдөх боломжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

НӨХӨРЛӨЛИЙН
ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

УЛААНБААТАР ХОТ

[4] "56.1.Дараах хэлцэл хүчин төгөлдөр бус байна: 56.1.1.хуульд зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл."



УЛААНБААТАР ХОТ
БЭРС ЭЙ БИ ЭС АКТИВ ТЗК ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Bers ABS active

**Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав:**

| | |
|---|---|
| 1. Овог, нэр:Б.Болор-Эрдэнэ<br><br>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Актив”ХХК-ийн ТУЗ-ийн дарга<br><br>Гарын үсэг:...............................................<br><br>(Тамга/тэмдэг) | 4 . Овог, нэр: Я.Оюумаа<br><br>Албан тушаал: Үүсгэн байгуулагч “Бэрс Финанс ББСБ”ХХК-ийн ТУЗ-ийн дарга<br><br>Гарын үсэг:...............................................<br><br>(Тамга/тэмдэг) |
| 2. Овог, нэр: С.Отгонбат<br><br>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Актив”ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн<br><br>Гарын үсэг:...............................................<br><br>(Тамга/тэмдэг) | 5. Овог, нэр: Б.Батхишиг<br><br>Албан тушаал: Андеррайтер “Мандал капитал маркетс ҮЦК”ХХК -ийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг:...............................................<br><br>(Тамга/тэмдэг) |
| 3. Овог, нэр: Д.Баатаржав<br><br>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “Бэрс Эй Би Эс Актив”ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн<br><br>Гарын үсэг:...............................................<br><br>(Тамга/тэмдэг) | |